

Баян-Өлгий аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1.	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг орон нутагтаа хэрэгжүүлнэ	40.0 сая	Арга хэмжээний тоо, гүйцэтгэлийн хувь	Арга хэмжээний тоо 1-3, гүйцэтгэлийн хувь 50%-100%	Арга хэмжээний тоо 1-14, гүйцэтгэлийн хувь 50%-100%	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 5 арга хэмжээ 100% биелэлттэй байна.	100%
1.1.1	“Жендерийн эрх тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо	0	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 2	ЕБ-ын 44 сургууль, 57 цэцэрлэгийн удирдах ажилтан, багш нарын төлөөлөл болох 140 гаруй багшид Жендерийн тухай хуулийг сурталчлан таниулах 1 удаагийн онлайн сургалт зохион байгуулсан. Сургуулийн удирдах ажилтан, багш нарын дунд жендерийн тухай хуулийн мэдлэг ойлголтын талаар google form ашиглан судалгаа авч нэгтгэсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу сумын сургуулиудад ажиллах үеэр сургууль,	100%

						<p>цэцэрлэгийн багш, ажилтнуудад жендерийн талаарх ойлголт өгч, дадлага ажилтай сургалтыг зохион явуулсан.</p> <p>Хүрсэн түвшин: 1</p> <p>Хавсралт: 2 файл</p>	
1.1.2	Үндэсний бичиг III хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	34%	Эхний хагас жилд: 40% Жилийн эцэст: 50%	<p>1. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнтэй хамтарч 40000 казах иргэдийн нэрсийг үндэсний бичгээр бичиж, толь бичгийн эмхэтгэл гаргах ажил төлөвлөсөн ба одоогийн байдлаар 7000 хүний нэрс бичиж бэлтгэсэн.</p> <p>2. Аймгийн хэмжээний монгол хэл бичгийн багш нарыг монгол хэл бичгийн төрөлжсөн олимпиадын I даваанд 100 хувь хамруулсан. Өгөгдсөн даалгаврыг багш нар 67,62 хувийн гүйцэтгэлтэй хийсэн нь цаашид монгол хэлний багш нарын онолын мэдлэгийг дээшлүүлэх хэрэгцээ гарч байгааг илтгэж байна.</p> <p>3. Монгол бичгийн улсын XVIII олимпиадын I даваа амжилттай зохион байгуулагдаж, 25 багш, 12 дугаар ангийн 20 сурагч оролцож, тэргүүн байранд шалгарсан багш,</p>	100%

						<p>сурагчдыг сургуулиудын дэмжлэгээр урамшуулж, II ын даваанд амжилттай оролцсон 4. Сурагчдын монгол бичиг сурах эрмэлзэлийг идэвхжүүлэх, сурах сонирхолтой болгох үүднээс 8-12 дугаар ангийн сурагчид болон монгол хэлний багш нарын дунд монгол бичгийн олимпиадыг зохион явуулж, БШУГ-аас урамшууллын мөнгийг гаргаж урамшуулсан болно. 5. Сургууль болон цэцэрлэгүүд бүх багш ажилчдыг үндэсний бичгийн сургалтад хамруулж, мэргэжлийн багш нараар хичээл заалгаж, цахим орчинд бүтээлийг нь байршуулж, түгээн дэлгэрүүлсэн болно.</p> <p>Хүрсэн түвшин: 80%</p> <p>Хавсралт: 18 файл</p>	
1.1.3	<p>Үндэсний цөөнхөд зориулсан хос болон олон хэлний боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, арга зүйгээр хичээл сургалт хөтлөн явуулах чадварыг дээшлүүлэхэд мэргэжлийн байгууллагуудтай</p>	Орон нутгийн төсөв	Хөтөлбөр хэрэгжсэн сургуулийн тоо, арга хэмжээний тоо	5, 0	Эхний хагас жилд: 10, 1 Жилийн эцэст: 36, 2	<p>БСҮХ-тэй хамтран “АХИС сургалтын арга зүйг түгээн дэлгэрүүлэх” 2 өдрийн сургалтыг 2024 оны 1-р сард аймгийн хэмжээний 45 сургуулийн удирдах ажилтан, багшийн төлөөлөл 125 хүнийг оролцуулан зохион байгуулсан. Бага боловсрол хариуцсан 30</p>	100%

	хамтран ажиллана					<p>сургалтын менежерт “АХИС сургалтын арга зүйгээр зорилтот хичээлүүдийг заах нь” 1,5 өдрийн сургалт зохион байгуулсан. Өлгий сумын ерөнхий боловсролын 1, 4, 7, 9 дүгээр сургууль, Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн багш нарт уг арга зүйгээр хичээл заах, төлөвлөх талаар туршилтын 2 сургуулийн зорилтот анги, хичээлийн багш нараар хичээл заалгаж, арга зүйн дэмжлэг үзүүлсэн</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p> <p>Хавсралт: 2 файл</p>	
1.1.4	“Тэрбум мод” үндэсний санаачилгыг орон нутагт хэрэгжүүлэн ажиллана	Орон нутгийн төсөв	Хамтран зохион байгуулсан байгууллагын тоо, гүйцэтгэлийн хувь	44 сургууль 56 цэцэрлэг, 90%	Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст: 100%	<p>“Тэрбум мод “ үндэсний хөдөлгөөнд нэгдэж, “Мод тарих” өдөрлөгийг 2024 оны 05-р сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Уг өдөрлөгт аймгийн төвийн 14 сургууль, 26 цэцэрлэгийн нийт багш, ажилчид идэвхтэй оролцож, хуваарилагдсан газарт 2000 ш мод тарьсан. Цаашид модыг услах, арчлах тал дээр анхааран ажиллаж байна.</p> <p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Ойн ангиас зохион байгуулсан мод тарих</p>	100%

						сургалтад холбогдох арга зүйчид хамрагдсан. Хүрсэн түвшин: 50% Хавсралт: 2 файл	
1.1.5	Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд” арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана	0	Хэрэгжилтийн хувь	70%	Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 90%	“Эрүүл шүд” арга хэмжээг сургууль цэцэрлэгт хэрэгжүүлэх тухай Монгол улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 322 дугаар тогтоол батлагдсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс аймгийн ЕБ-ын сургуулиуд Нэгдсэн эмнэлгийн “Өсвөр үе залууст ээлтэй кабинет”, өрхийн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн шүдний эмч нартай хамтарч хүүхдийг шүд угаах арга барилд сургах, амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, эрүүлжүүлэх арга хэмжээ авах зорилгоор ЕБС-ийн бага ангийн нийт 6221 сурагчдыг хамруулан сургалт, сурталчилгаа явуулсан. Мөн сургууль болгон шүд угаах цаг болон эрүүл ахуйн шаардлага хангасан шүд угаах хэсэг бий болгож, хэвшил болгон ажиллуулж эхэлж байна. Хүрсэн түвшин: 80%	100%

						Хавсралт: 1 файл	
1.2.	Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарыг орон нутагт хөгжүүлнэ	0	Бүтээлийн тоо	0	2	Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарыг орон нутагт хөгжүүлэх зорилтын хүрээнд 3 арга хэмжээ төлөвлөснөөс биелэлт 100%-тай байна. Шинжлэх ухаан, инноваци, технологийг хөгжүүлэх 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан шаардагдах хөрөнгө болох 10.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлсэн. Энэ зорилтын хүрээн дэх зарим арга хэмжээнд тодорхой хэмжээний санхүүжилт шаардагдах учраас эхний хагас жилд төлөвлөсөн ажлаа бүрэн гүйцэтгэсэн ба хоёр дахь хагас жилд хуваарилагдсан санхүүжилтийн дагуу ажил зохион байгуулан тодорхой үр дүн гаргана гэж үзэж байна.	100%
1.2.1	Аймаг, орон нутагт шинжлэх ухаан, инноваци, технологийг хөгжүүлэх 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан шаардагдах зардлыг орон нутгийнхаа 2024	Орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: 30% Жилийн эцэст: 100%	Төлөвлөгөө боловсруулан шаардагдах хөрөнгө болох 10.0 сая төгрөгийг Орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлсэн. Төлөвлөсөн ажил хэрэгжих шатандаа байна. Хүрсэн түвшин: 30%	100%

	оны төсвийн багцаас санхүүжүүлж, хэрэгжилтийг хангана						
1.2.2	Аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн болон гарааны бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулна	0	Арга хэмжээний тоо	2	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 2	"Өлгий сүү" компанийн эрчимжсэн үнээний аж ахуй эрхлэгчид орон нутгийн хэрэглэгчдийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах, бүтээгдэхүүний нэр төрлийг уламжлалт болон орчин үеийн арга технологитой хослон хөгжүүлж байгааг сайшаан ЖДҮ-ийн сангаас 140.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хүрсэн түвшин: 1	100%
1.2.3	Аймаг, орон нутгийнхаа байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн инновацийн төсөл, грантыг сонгон шалгаруулна	Орон нутгийн төсөв 20.0 сая	Бүтээлийн тоо	0	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1	"Асылмура кесте" компанийн хонины ноос боловсруулж, хатгамал бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинэ технологи гарган ажиллаж байгаа ба ЖДҮ-ийг дэмжих сангаас 70,0 сая төгрөг олгосон. Хүрсэн түвшин: 1	100%
1.3.	Боловсролын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулна	0	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна /хувь/	100%	100%	Боловсролын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах зорилтын хүрээнд 15 арга хэмжээ төлөвлөгдснөөс биелэлт 95.3%-тай байна. 1.3.7 дахь арга хэмжээний биелэлт 60%-тай гарсан нь стандартын шаардлага хангасан барилга	95.3%

						байгууламжгүй, өөрийн гэсэн орон байргүй, түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг, хоол үйлдвэрлэлийн зориулалтын газаргүй, тоног төхөөрөмжийн хангалт дутмаг байдлаас эрүүл ахуй стандартын шаардлага хангагдахгүй байна. Мөн сургууль, цэцэрлэг, дотуур байруудад орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт тогтмол хийж хэвшсэн боловч төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдлаас халдваргүйжүүлэх бодисын нөөц бүрдүүлэх, мэргэжлийн байгууллагаар ариутгал хийлгүүлэх ажил дутагдалтай биелэгдсэн байна.	
1.3.1	Сурах бичгийн хангамжийн судалгааг авч, шинэчлэх, дахин хэвлэх асуудлыг судлан БЕГ-т санал хүргүүлэх	0	Гүйцэтгэлийн хувь	60%	Эхний хагас жилд: 65% Жилийн эцэст: 70%	Сурах бичгийн хангамжийн судалгааг ерөнхий боловсролын сургуулиудаас авч, 1-5 дугаар ангийн 42,347 сурах бичиг, 6-12 дугаар ангийн 3,504 сурах бичгийг дахин хэвлүүлэхээр БЕГ-т саналаа хүргүүлсэн. Хос хэлээр сургалт явуулдаг сургуулиудын бага ангийн сурах бичгүүд болон өмнөх хичээлийн жилд дэлхийн банкны санхүүжилтээр	100%

						<p>хэвлэгдсэн монгол хэлний хичээлийн сурах бичиг, дасгал ажлын дэвтэрийг БШУЯ-ны санхүүжилтээр хэвлэж өгөх санал, судалгааг сурах бичгийн захиалгад нэмж БЕГ-т хүргүүлсэн.</p> <p>Хүрсэн түвшин: 65%</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.3.2	<p>Сургалтын байгууллагын эзэмшил газрыг баталгаажуулах, сургууль, цэцэрлэгийн эдэлбэр, эзэмшил газарт зориулалтын бус барилга байгууламж, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй, ашиглуулахгүй байх, сургалтын байгууллагын барилгад боловсрол, сургалтын үйл ажиллагаанд ашиглахаас өөр зориулалтаар өргөтгөл нэмж барихгүй байх, барилга угсралтын гэрээний хэрэгжилтийг хангаж, цаг хугацаанд нь ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх, хяналт шалгалт хийх</p>	0	Хэрэгжилтийн хувь	100%	<p>Эхний хагас жилд: 100%</p> <p>Жилийн эцэст: 100%</p>	<p>Аймгийн хэмжээнд 57 хүүхдийн цэцэрлэг, 44 ерөнхий боловсролын сургууль, 1 мэргэжлийн боловсролын сургууль, 1 дээд боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба сургууль, цэцэрлэгийн эзэмшил газрыг зориулалтын дагуу ашиглаж байгаа болно. Сургууль, цэцэрлэгийн эзэмшил газарт гадны объект байрласан, зориулалтын бус барилга байгууламж баригдсан, үйл ажиллагаа явуулсан зөрчил илрээгүй. Боловсрол, шинжлэх ухааны салбарт 2024 онд хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлын явцад аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас тогтмол хяналт тавьж ажиллаж, аймгийн</p>	100%

						<p>БШУГ-аас хөрөнгө оруулалтын ажлын явцын мэдээллийг сар бүр Боловсролын ерөнхий газарт хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.3.3	<p>Аймаг, нийслэлийн хэмжээнд багш, ажилтны ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах, багш, удирдах болон бусад ажилтныг ёс зүйгүй аливаа үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж үр дүнг тооцож ажиллах</p>	0	<p>Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо</p>	2	<p>Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 2</p>	<p>Газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар байгууллагын ёс зүйн дэд хороо 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинээр байгуулагдаж, жилийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. Мөн аймгийн хэмжээний төрийн өмчийн 39 ерөнхий боловсролын сургууль, 51 хүүхдийн цэцэрлэгт газрын даргын албан бичгийг хүргүүлэн ёс зүйн дэд хороог байгуулан ажиллуулж байна. Төрийн албаны зөвлөлөөс зохион явуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад БШУГ-ын бүх арга зүйч, мэргэжилтнүүд, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчид, сургууль, цэцэрлэгийн ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд бүгд 182 хүн хамрагдсан. БШУГ-ын ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн</p>	100%

						<p>дарга Улаанбаатар хотод зохион байгуулагдсан 2 өдрийн ёс зүйн сургалтад хамрагдаж сертификаттай болсон. Сургууль, цэцэрлэгийн ёс зүйн дэд хороог хууль, журмын дагуу ажиллуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион явуулах газрын даргын албан даалгаврыг бүх сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт хүргүүлсэн.</p> <p>Хүрсэн түвшин: 1</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.3.4	Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага” үндэсний стандартын шаардлагад нийцүүлэх, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмж, орчинд хяналт, үнэлгээ хийх, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна	0	Хүнсний хангамж, үйлчилгээний чанар аюулгүй байдал, хүртээмжийн хувь	100%	Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100%	2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-ийн 39 төрийн өмчийн сургуулийн бага ангийн 490 бүлгийн 12151 суралцагч “Үдийн хоол” хөтөлбөрт хамрагдах ёстойгоос БСШУ, ЭМ-ийн сайдын 379/341 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан ЕБС-ийн “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмын дагуу 2024 оны 01-р сарын 28 хүртэл 97,4% буюу 38 сургууль долоо хоногийн 5 өдөр халуун хоолоор үйлчилж байна. Энэ хичээлийн жилд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг аж	100%

					<p>ахуйн нэгжээр гүйцэтгүүлж байгаа нийт 12 сургуулиас Монгол Улсын Засгийн газрын “Төлөвлөгөө батлах тухай” 2021 оны 18 дугаар тогтоолын дагуу 6 ерөнхий боловсролын сургууль түрээсийн гэрээг дуусгавар болгож, бие даан ажиллуулж эхэлсэн. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, шаардлага хангасан зориулалтын байргүй ерөнхий боловсролын сургуулиудын судалгааг авч, аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд Өлгий сумын ерөнхий боловсролын 3 сургуульд гал тогооны өргөтгөл барих санал оруулсан. ЕБС-ийн үдийн хоолны илчлэг, шимт бодисын хэмжээг тодорхойлон, тогтоосон норм хэмжээг хангаж буй эсэхэд үнэлгээ дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, эрсдэлийг бууруулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
--	--	--	--	--	--	--

1.3.5	Хичээлийн жилийн бүтцийг мөрдөх, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах, сургалтын цахим платформыг хөгжүүлэх, цар тахлын улмаас үүссэн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад тусгайлсан арга хэмжээ хэрэгжүүлнэ	0	Сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулсан сургуулийн тоо	44	Эхний хагас жилд: 44 Жилийн эцэст: 44	Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулиуд БШУ-ны сайдын 2023 оны А/350, А/398, А/20 дугаар тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах үүднээс судлагдахуун бүрээр бэлтгэсэн нийт 430 цахим хичээлийн сантай байна. Сургалтын хоцрогдолыг арилгах чиглэлээр сургуулиуд өөрсдийн онцлог, гарааны үнэлгээг тогтоож судлагдахуун бүрээр сургалтын төлөвлөгөө боловсруулан танхимаар болон онлайн сургалтын арга зүйг хослуулан үйл ажиллагаагаа явуулж байна. БШУГ-аас МХБ-тэй хамтран судлагдахуун бүрээр даалгаварын санг баяжуулж, шалгалт авч, дүн шинжилгээ хийж, ажиллаж байна. Хүрсэн түвшин: 44	100%
1.3.6	Боловсрол, шинжлэх	0	Арга	0	Эхний хагас	Багшийн ажлын байранд	100%

	<p>ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/23, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ (2023-2026)”, “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж ажиллана</p>		<p>хэмжээний тоо</p>		<p>жилд: 2 Жилийн эцэст: 4</p>	<p>мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, мэдлэг, ур чадвар, арга зүй, сургалт үйл ажиллагааны онцлогтой танилцаж, сургалтын чанарыг сайжруулах, хүүхдийн сурч хөгжих үйл явцыг илүү таньж мэдэх, ахиц амжилтыг бодитоор үнэлэх, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрхэн хэрэгжүүлж буй талаарх сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлж, бие биеэсээ суралцан хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан болно. Аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын арга зүйч багш нарт ур чадварыг сайжруулах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Шимт боловсрол” ХХК, аймгийн БШУГ-тай хамтран сургалт зохион байгуулав. Сургуулийн өмнөх боловсролын менежментийг туршин хэрэгжүүлж буй Өлгий сумын хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн нийт багш нар уг сургалтад бүрэн хамрагдаж, STEM сургалтын хэрэглэгдэхүүний ач</p>
--	---	--	----------------------	--	------------------------------------	---

						<p>холбогдол, үр дүнтэй ашиглаж буй туршлага, сургалтад ашиглах арга зүйн талаар уг сургалтын үеэр ярилцаж туршлага солилцсон ажиллав.. Бага насны хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх STEAM хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар аймгийн 54 цэцэрлэг бүрээс 3 хүнийг Шимт боловсрол ХХК-ны сургалтад хамруулсан ба Өлгий сумын 6-р цэцэрлэгт "Тоглонгоо хөгжье" сургалтын хэрэглэгдэхүүн авч сургалтдаа ашиглаж байна. Шимт хөтөлбөрийг хэрэгжүүлж буй цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулагдсан MONGOLIA GREENMECH улсын уралдаанд Өлгий сумын 6 дугаар хүүхдийн цэцэрлэгийн багачууд "Тусгай байр" эзэлж, амжилттай оролцлоо</p> <p>Хүрсэн түвшин: 2</p> <p>Хавсралт: 3 файл</p>	
1.3.7	Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хүүхдийн эрүүл ахуйн стандартыг хангуулах, сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчны ариутгал, цэвэрлэгээ,	0	Сургууль, цэцэрлэгийн тоо	101	Эхний хагас жилд: 30 Жилийн эцэст: 101	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн суралцах орчны эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн байдал 60%-тай. Стандартын шаардлага хангасан барилга	60%

<p>халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх, багш ажилтнууд болон сурагчдын гар угаах, ариун цэврийн орчныг сайжруулах, саван ариутгалын бодисын хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулна</p>						<p>байгууламжгүй, өөрийн гэсэн орон байргүй, түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг, хоол үйлдвэрлэлийн зориулалтын газаргүй, тоног төхөөрөмжийн хангалт дутмаг байдлаас эрүүл ахуй стандартын шаардлага хангагдахгүй байна. Сургууль, цэцэрлэг, дотуур байруудад орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт тогтмол хийж хэвшсэн боловч төсөв санхүүгийн хүрэлцээгүй байдлаас халдваргүйжүүлэх бодисын нөөц бүрдүүлэх, мэргэжлийн байгууллагаар ариутгал хийлгүүлэх ажил дутагдалтай. Сурагчдын гар угаах, ариун цэврийн орчныг сайжруулах ажлын хүрээнд сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих төсөл дэс дараатай хэрэгжиж байгаа ба сургуулиуд батлагдсан төсвийн хүрээнд сурагчдын гар угаах саван, ариутгалын бодисоор тогтмол хангаж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 18</p>
--	--	--	--	--	--	--

						Хавсралт: 10 файл	
1.3.8	Ялгаатай хэрэгцээтэй (малчин өрхийн, хилчдийн, хөгжлийн бэрхшээлтэй, хүнд нөхцөлд амьдарч буй, шашны сургуульд суралцаж буй, хэл соёлын ялгаатай хүүхдүүд) хүүхдийг боловсролд тэгш хамруулах, хөгжлийг дэмжих ажлыг орон нутгийн хэмжээнд удирдан зохион байгуулна	0	Арга хэмжээний тоо	0	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 3	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн болон тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нарийвчилсан дэлгэрэнгүй судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран шинэчлэн гаргасан. Энэ хичээлийн жилийн байдлаар ЕБСургуульд 258, цэцэрлэгт 65 хүүхэд хамрагдаж байгаа нь өнгөрсөн оныхоос ахисан үзүүлэлттэй байна. Цаашид сургууль, цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар захирал, эрхлэгч нартай байгуулсан гүйцэтгэлтйн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд тусгаж өгсөн болно. Хүүхдийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд Норвегийн тусламжийн байгууллагатай хамтран Өлгий сумын 4 дүгээр цэцэрлэг, 10 дугаар сургуульд 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн хүүхэд амрах өрөөтэй болгосон Хүрсэн түвшин: 2 Хавсралт: 4 файл	100%
1.3.9	Ерөнхий боловсролын сургуулийн	0	Арга	0	Эхний хагас жилд: 1	Иргэний ёс зүйн боловсрол хичээлийн агуулга болон	100%

	суралцагчдад нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцах, 21-р зууны иргэнд шаардагдах хувь хүний ур чадвар олгох хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ		хэмжээний тоо		Жилийн эцэст: 2	хичээлээс гадуурх үйл ажиллагаа, дугуйлан, секцээр дамжуулан нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйд суралцах, 21-р зууны иргэнд шаардагдах хувь хүний ур чадваруудыг эзэмшүүлэн, чиглүүлж байна. Аймгийн хэмжээнд нийт давхардсан тоогоор 25 дугуйланд 8000 орчим хүүхэд тогтмол хамрагдаж байна. Хүрсэн түвшин: 1	
1.3.10	МУБИС-ийн Моноцүкүри төвөөс нийлүүлсэн физикийн туршилт хичээлийн хэрэглэгдэхүүнийг сургалтад ашиглахыг дэмжинэ	0	Сургуулийн тоо	11	Эхний хагас жилд: 16 Жилийн эцэст: 26	Моноцүкүри төвөөс нийлүүлсэн физикийн туршилт хичээлийн хэрэглэгдэхүүн нь 10 дугаар ангийн 4-р улиралд орох Электроник систем бүлэг сэдвийн хүрээнд ашиглагддаг. Өнгөрсөн жил аймгийн хэмжээнд уг хэрэглэгдэхүүн ганц байсан тул зөвхөн аймгийн төвийн сургуулиуд хамтарч ашигладаг байсан бол 2024 оны 2-р сард дахин нэг сургалтын хэрэглэгдэхүүн нэмэгдэж ирснээр хөдөө сумдын сургуулиуд ч ашиглах боломж бүрдэж байна. Энэхүү хэрэглэгдэхүүнийг сургалтад ашиглах талаархи сургалтыг 3-р улирлын амралтаар бүх	90%

						<p>сургуулийг мэргэжлийн багш нарт зохион байгуулсан. Багажийг аймгийн төвийн 11, Бугат, Сагсай, Толбо сумын ерөнхий боловсролын сургуулийн багш нар хичээлдээ ашигласан</p> <p>Хүрсэн түвшин: 14</p> <p>Хавсралт: 5 файл</p>	
1.3.11	<p>Орон нутгийн өмчийн цэцэрлэг, сургуулийн бүтэц, хэв шинж, орон тооны жишиг норматив, бүлэг дүүргэлтийн стандартыг баримтлан, сургууль, цэцэрлэгийн хэв шинж, стандарт, орон тоо, бүлгийн тооны зохистой байдлыг хангана</p>	0	Хэрэгжилтийн хувь	70%	<p>Эхний хагас жилд: 75%</p> <p>Жилийн эцэст: 80%</p>	<p>Сургууль, цэцэрлэгүүд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа ба бүлэг дүүргэлтийн норм нормативыг хангаагүй Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2 бүлгийг нэгтгэж, зөрчлийг арилгасан. Тус аймгийн 39 ерөнхий боловсролын сургуулийн 27 ерөнхий боловсролын сургуульд БСШУС-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 тушаалаар баталсан багшаас бусад ажилтны жишиг нормативаас илүү 171 хүн ажиллаж байсан. БЕГ-аас ирүүлсэн албан шаардлага, акт, аймгийн БШУГ-аас хүргүүлсэн албан даалгаврын мөрөөр 79 хүнийг ажлаас чөлөөлж, 19 хүнийг тэтгэвэрт гаргаж,</p>	100%

						<p>44 хүн өөр албан тушаалд шилжин, 4 хүн чөлөө авсан болно. Одоо тодорхой шалтгаантай 37 хүний асуудал шийдэгдээгүй ба тус оны эцэс хүртэл шийдэгдэх болно.</p> <p>Хүрсэн түвшин: 80%</p> <p>Хавсралт: 2 файл</p>	
1.3.12	<p>Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдад эрүүл мэндийг дэмжсэн “Өглөөний цай”, “Сүү” хөтөлбөрийг хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ</p>	0	Хэрэгжилтийн хувь	20%	<p>Эхний хагас жилд: 0 Жилийн эцэст: 50%</p>	<p>Тус хөтөлбөрийн талаар ЕБ-ын сургуулиудын удирдлагуудад танилцуулж, хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангуулж байна. Хувийн өмчийн 5 ерөнхий боловсролын сургууль бага ангийн 669 суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч нартай гэрээ байгуулж, үдийн хоол хөтөлбөрийн 1 өдрийн халуун хоолны оронд сүү, тараг, аарц олгож байна.</p> <p>Хүрсэн түвшин: 30%</p> <p>Хавсралт: 2 файл</p>	100%
1.3.13	<p>Орон нутагт төрийн болон төрийн бус байгууллага иргэдийн оролцоог хангасан орон тооны бус Хүүхдийн хоолны зөвлөлийг байгуулж хуулийн хэрэгжилт, үр дүнг хэлэлцэх, холбогдох</p>	0	Хэрэгжилтийн хувь	0	<p>Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст: 100%</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 21-ий өдрийн А/20 дугаар тушаалын дагуу 39 төрийн өмчийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих</p>	100%

	шийдвэрийг гаргах олон талт хамтын ажиллагааг бэхжүүлж, хяналт тавина					орон тооны бус “Хүүхдийн хоолны хяналтын зөвлөл” байгуулж, нийт 39 хяналтын зөвлөл нь 175 гишүүнтэй ажиллаж байна. Хяналтын зөвлөл тогтмол ажилласнаар энэ хичээлийн жилд ямар нэгэн хоолны хордлого, зөрчил гараагүй, хоолны хүртээмж, илчлэг, чанар сайжирсан болно. Хүрсэн түвшин: 0 Хавсралт: 2 файл	
1.3.14	Суралцагч, багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж, ЕБС-ийн суралцагчийг тодорхой насны давтамжтай хамруулах үйл ажиллагааг зохион байгуулна	Улсын төсөв	Хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст: 80%	Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт СӨБ-ын 256 багш, ажилтан хамрагдсан. ЕБС-ийн суралцагчдыг Өрхийн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төв, сургуулийн эмч нартай хамтран тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулж байна. Хүрсэн түвшин: 50% Хавсралт: 1 файл	100%
1.3.15	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд “Хүүхэд хөгжлийн өрөө”, “Охидын ариун цэврийн булан” байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна	0	Хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: 40% Жилийн эцэст: 80%	“Охидын ариун цэврийн булан” нөлөөллийн ажлыг Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, ЕБ-ын 11 сургуулийн дотуур байрыг / Алтай ЕБС, Буянт ЕБС, Сагсай 1 дүгээр,	80%

						<p>ЕБС, Цэнгэл 1 дүгээр ЕБС, 6 дугаар ЕБС, Ногооннуур 1,2,3 дугаар сургууль, Емпати, Зайд, Дэлүүн 1 дүгээр ЕБС/ хамрууллаа. Хүүхдийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор хүүхэд хөгжлийн төвийг бүх дотуур байр ажиллуулж байгаа. Аймгийн хэмжээнд 13 стандартын бус дотуур байр байгаа бөгөөд багтаамж муу, орчин нөхцөл бүрдээгүй дотуур байранд хүүхэд хөгжлийн өрөөг байгуулсан ч шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.</p> <p>Хүрсэн түвшин: 80%</p> <p>Хавсралт: 3 файл</p>	
1.4.	“Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, багшийн үнэлэмж, бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоог нэвтрүүлнэ	Улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	Арга хэмжээний тоо, оролцогчдын тоо	Арга хэмжээний тоо-1	Арга хэмжээний тоо-5	“Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, багшийн үнэлэмж, бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоог нэвтрүүлэх зорилтын хүрээнд 9 арга хэмжээ төлөвлөгдснөөс биелэлт 98.8%-тай байна.	98.8%
1.4.1	“EDUTEN” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, багш нарыг чадваржуулах сургалтыг зохион байгуулах, хөтөлбөрийн	БШУЯ, БЕГ	Хэрэгжсэн сургуулийн тоо	39	Эхний хагас жилд: 39 Жилийн эцэст: 39	EDUTEN хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд анги дааж авдаг 1-5 дугаар ангийн багш нарын судалгааг	100%

	<p>хэрэгжилтэд хяналт тавих</p>				<p>гаргаж, 44 сургуулийн 88 багшид сургалт явуулсан. Аймгийн хэмжээнд сургуулиуд орчноо сайжруулах, интернетийн хурд, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлуудыг хийснээр идэвхтэй суралцагчдын тоо нэмэгдэж, аймгийн хэмжээний хандалтын хувь нэмэгдсэн. Зарим сургуулиуд дан EDUTEN-ий хичээл ордог анги танхимийг тусад нь гаргаж, таблет, ухаалаг самбар, компьютерээр хангаж өгсөн байна. Сургалтын менежерүүдэд EDUTEN платформ дээр ажиллах, хяналт хийх арга зүйн сургалтыг явуулсан. Аймгийн төвийн сургуулиудад мониторинг хийж, EDUTEN платформ дээр ажиллах арга зүйн зөвлөмж боловсруулан сургуулиудад хүргүүлсэн. 2023-2024оны хичээлийн жилд уг хөтөлбөрийг 3.4 дүгээр ангид амжилттай хэрэгжүүлж БҮТ-өөс мониторингийн шалгалт авсан ба уг шалгалтыг амжилттай өгсөн. Аймгийн дундаж намар 51 хувь байсан бол жилийн эцэст 4 дүгээр анги 70 хувь, 3 дугаар анги 68 хувьтай</p>	
--	---------------------------------	--	--	--	--	--

						<p>үнэлэгдсэн байна. 2024-2025 оны хичээлийн жилд бүх ангид уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх учраас үлдсэн 1,2,5 дугаар ангийн багш нар EDUTEN-ий хөтөлбөрт бүртгүүлж хичээлүүдээ судлан сертификатаа авч байгаа.</p> <p>Хүрсэн түвшин: 39</p> <p>Хавсралт: 4 файл</p>	
1.4.2	<p>Багш нарыг гадаад, дотоодын /төвлөрсөн, орон нутгийн/ танхим болон онлайн сургалтад хамруулж, захиалгат сургалт зохион байгуулна</p>	<p>Орон нутгийн төсөв 11.5 сая</p>	<p>Хамрагдсан багшийн тоо</p>	<p>Гадаад-31, дотоод-4800 /удирдах ажилтан, багш хамрагдсан/</p>	<p>Эхний хагас жилд: гадаад-10 дотоод-1720 удирдах ажилтан, багш хамрагдсан, давхардсан тоогоор Жилийн эцэст: гадаад-20 дотоод-3500 удирдах ажилтан, багш хамрагдсан, давхардсан тоогоор</p>	<p>2024 оны 1 дүгээр сард “АХИС сургалтын арга зүйг түгээн дэлгэрүүлэх” сургалтад 125 багш, сонгон судлах хичээл зааж буй багш нарт зориулсан “ЭЕШ-д амжилттай бэлтгэх аргачлал, туршлага, сургамж” сургалтад 293 багш, сургуулийн удирдлагуудын “Сургуулийн менежментийг сайжруулах” сургалтад 133 захирал, сургалтын менежер, “Нийгмийн ажилтныг чадавхжуулах” сургалтад 24 нийгмийн ажилтан, “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сургалтад 133 захирал, сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, “Өлгий сумын ерөнхий боловсролын 1, 4, 7, 9 дүгээр сургууль, Бугат сумын ерөнхий</p>	100%

					<p>боловсролын сургуулийн 86 багшид захиалгат сургалт авсан. Орос хэлний 42 багш ОХУ-ын Горно-Алтайн Улсын их сургуулиас захиалгат сургалт, Дэлүүн сумын ерөнхий боловсролын сургуулийн 30 багш ОХУ-ын мөн БШУГ-ын гадаад хэлний боловсрол хариуцсан арга зүйчээр ахлуулсан 6 багш Горно-Алтайн Улсын их сургуулиас зохион байгуулж буй “Орос хэлний багш нарын бага хурал”-д оролцлоо. Бага ангийн багш нарт “Дижитал багш”, “Нэгж хичээлийн төлөвлөлт боловсруулах, үнэлгээний шалгуурыг ашиглах арга зүй” сургалтыг явуулж давхардсан тоогоор 180 багш хамрагдсан. СӨБ-ын хөдөлгөөн, эрүүл мэндийн мэргэжлийн бүлгийн багш нарын туршлага судлах сургалтад цэцэрлэгийн биеийн тамирын 43 багш, цэцэрлэгийн хөгжмийн багш нарын туршлага судлах, хөгжимт хөдөлгөөн заах арга барилд сургах, чадваржуулах үзүүлэх сургалтад 47 хөгжмийн багш, “Шимт” ХХК-тай хамтран “STEAM бага</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>насны хүүхдийн оюуны хөгжлийг дэмжих хэрэглэгдэхүүн арга зүй” сургалтад 53 багш, 44 арга зүйч хамрагдсан. Монгол хэл бичгийн багш нар эх хэлээрээ найруулан бичих, зөв бичих чадварыг дээшлүүлэх, сургалтыг сургуулиудад үе шаттай зохион байгуулж, мэргэжлийн хөгжлийн бүлэг хамтран ажиллаж, мэргэжлийн байгууллага арга зүйгээр хангаж ажилласан. МДҮС-д сургууль, цэцэрлэгийн 548 багш, удирдах ажилтан хамрагдсан</p> <p>Хүрсэн түвшин: гадаад-78 дотоод-1576 удирдах ажилтан, багш хамрагдсан, давхардсан тоогоор</p> <p>Хавсралт: 4 файл</p>		
1.4.3	Ээлжит чанартай байгуулахад мэргэжлийн хамтран багшийн тасралтгүй дээшлүүлэхэд үзүүлнэ	хичээлийг зохион бүлгээр ажиллаж, хөгжлийг дэмжлэг	0	Зөвлөгөө өгч хамтран ажилласан багшийн тоо	1200	Эхний хагас жилд: 900 Жилийн эцэст: 1765	Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцах, дүн шинжилгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх ажлаар БШУГ-ын даргын удирдамжийн дагуу Цэнгэл сумын 1, 2, 3, 4 дүгээр сургууль, Улаанхус сумын 1, 2, 3 дугаар сургууль, Булган сумын ЕБ-ын сургууль, Сөнхөл багийн ЕБ-ын сургууль, Сайхан	100%

					<p>багийн ЕБ-ын сургууль цэцэрлэгүүдэд ажиллаж, 342 багш, удирдах ажилтанд сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Арга зүйчид хариуцсан багш нарын хичээлд нь сууж, ээлжит хичээлийн хөтөлбөр, бэлтгэл ажилтай танилцан зөвлөн тусалсан. Гадаад хэл болон бага ангийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн багш нар хариуцсан арга зүйчидтэй хамтран Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуульд ажиллан, нийт 53 багшид нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан. Бага ангийн казах хэлний мэргэжлийн хөгжлийн бүлгээс бага ангийн багш нарын дунд казах хэлний олимпиад болон уралдаан зохион явуулж, нийтдээ 88 багш олимпиадад, 15 баг уралдаанд оролцлоо. Ээлжит хичээлийг чанартай зохион явуулах үүднээс 1-р ангийн багш нарын дунд “Үсэг заах” арга зүй, 2-5 дугаар ангийн багш нар “Монгол хэлний хичээлээр” үзүүлэх хичээлүүдийг явуулж, аймгийн төвийн</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>сургуулиудын багш нар БШУГ-ын даргын удирдамжийн дагуу Цэнгэл сумын 1, 2, 4 дүгээр сургууль, Улаанхус сумын 1, 2, 3 дугаар сургуулиудад ажиллахдаа нийт 13 казах хэл, уран зохиолын багш нарын хичээлд нь сууж, ээлжит хичээлийн хөтөлбөр, бэлтгэл ажилтай танилцан тухайн хичээлийн явцад гаргасан алдаа дутагдлыг ойлгуулж, ололтыг нь сайшааж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Хүрсэн түвшин: 900</p> <p>Хавсралт: 4 файл</p>	
1.4.4	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулна	Улсын төсөв	Арга хэмжээний тоо	5	Эхний хагас жилд: 2 Жилийн эцэст: 4	<p>“Хамтын оролцоонд суурилсан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь” эрдэм шинжилгээний хуралд ирүүлсэн 93 илтгэлийг хэлэлцүүлж, 2 дугаар шатны шалгаруулалтад 20 илтгэгч оролцсон. Эхний байр эзэлсэн 2 илтгэлийг дахин сайжруулж, 3 дугаар шатанд ЕБ-ын 2, СӨБ-ын 1 багш амжилттай оролцсон.</p> <p>Хүрсэн түвшин: 2</p>	100%
1.4.5	“PEARSON” англи	БШУЯ, БЕГ	Хэрэгжсэн	39	Эхний хагас	“PEARSON” хөтөлбөрийг	100%

	хэлний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, багш нарыг чадваржуулах сургалтыг зохион байгуулах, “Welcome” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих		сургуулийн тоо		жилд: 39 Жилийн эцэст: 39	хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаа онлайн сургалтыг зохион байгуулсан. Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн багш нарт хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцтай холбогдуулан сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгсөн. “Сайн хичээл-үйл ажиллагаа”-нд 4 багш хөтөлбөрийн дагуу 5, 6 дугаар ангид хичээл зааж, бусад багш нартай туршлага солилцсон. “Welcome” хөтөлбөрийг ерөнхий боловсролын 5 дугаар сургуульд хэрэгжүүлж, нийт 21 сурагч долоо хоногт 2 өдөр хичээллэж байна. Хүрсэн түвшин: 39 Хавсралт: 5 файл	
1.4.6	Багш нарын цахим контент бэлтгэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дээрээ хөгжих орчныг бүрдүүлэх, medle.mn дээр хичээл байршуулна	Улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	Байршуулсан хичээлийн тоо, зохион байгуулсан сургалтын тоо	Байршуулсан хичээлийн тоо-100, зохион байгуулсан сургалтын тоо-15	Эхний хагас жилд: Байршуулсан хичээлийн тоо-50, зохион байгуулсан сургалтын тоо-8 Жилийн эцэст: Байршуулсан хичээлийн тоо-120, зохион байгуулсан	Багш, удирдах ажилтнуудыг мэдээлэл холбооны технологи ашиглах чадварыг дээшлүүлэх чиглэлээр БШУГ-ын дэргэдэх цахим сургалтыг түгээн дэлгэрүүлэх баг сургуулиудад ажиллаж “Цахим шилжилт-багшийн хөгжил” сэдэвт сургалтыг зохион байгуулснаар багш нарын ажлын байран дээр	100%

					сургалтын тоо-12	<p>мэргэжил дээшлүүлэхэд ихээхэн тус нэмэр оруулж чадсан. Үүгээр багш нарын цахим контент бэлтгэх, ээлжит хичээлийг цахим орчинд өөртөө хэрэгцээтэй мэдээллийг олж, интерактив хичээл бэлтгэхэд МХТ-ийг ашиглах чадвар дээшилж байна. ЕБС-ийн багш нарыг чадавхжуулах “ЦАХИМ ШИЛЖИЛТ-БАГШИЙН ХӨГЖИЛ” сэдэвт захиалгат сургалтыг Алтай сумын ЕБ-ын 1, Цэнгэл сумын 2, 3, Баяннуур сумын 1, 2 дугаар сургууль, Алтай, Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 220 багш, удирдах ажилтнууд хамрагдсан.</p> <p>Хүрсэн түвшин: зохион байгуулсан сургалтын тоо-8</p> <p>Хавсралт: 2 файл</p>	
1.4.7	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн байгалийн ухаан, технологи, инженер, математикийн (STEM) сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ	0	Арга хэмжээний тоо	0	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1	STEM хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдийн авьяасыг хөгжүүлэх, байгаль ухааны хичээлд сонирхлыг нь татах зорилгоор сургуулиудад чиглэл хүргүүлэн ажиллаж байна. STEM-ийн хичээлийг ордог тусдаа цаг байдаггүй учраас багшийн	100%

	хэрэгжүүлнэ					40 цагт оруулж, дугуйлан секц болгон хичээллүүлж байна. Зарим сургуулиуд EDUTEN болон STEM-ийг оруулдаг тусдаа анги танхим тохижуулж, хүүхдүүдийг хичээллүүлж байна. Хүрсэн түвшин: 1 Хавсралт: 4 файл	
1.4.8	Ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, багш нарыг мэргэжлийн бүлэг байгуулан харилцан бие биенээсээ суралцахад дэмжлэг үзүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлнэ	Орон нутгийн төсөв 8.0 сая	Багш нарын тоо	231	Эхний хагас жилд: 204 Жилийн эцэст: 408	Өлгий сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 6, 3 дугаар сургууль 1, 6 дугаар сургууль 2, 10 дугаар сургууль 2, Улаанхус сумын Согоог багийн ЕБС 1, Дэлүүн ЕБС 1, Алтай сумын Улаанхад багийн ЕБС 2, Толбо сумын ЕБС 3, Бцянт сумын ЕБС 1, Цэнгэл сумын ЕБ-ын 3 дугаар сургууль 1, нийт 20 ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг авсан. Ерөнхий боловсролын сургууль бүрт судлагдахуун болон суралцахуйд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлэг, БШУГ-ын дэргэд судлагдахууны зөвлөх баг, аймгийн зөвлөх багш нарын баг ажиллаж байна. БШУГ-ын даргын удирдамжаар аймгийн хэмжээний цэцэрлэгүүдийн	100%

						<p>сайн туршлагыг түгээх үйл ажиллагааг зохион байгуулсан. Уг туршлага солилцох үйл ажиллагаанд цэцэрлэгийн багшийн ажлын байранд мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, мэдлэг, ур чадвар, арга зүй, сургалт үйл ажиллагааны онцлогтой танилцаж, сургалтын чанарыг сайжруулах, хүүхдийн сурч хөгжих үйл явцыг таньж мэдэх, ахиц амжилтыг бодитоор үнэлэх, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрхэн хэрэгжүүлж буй талаарх сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлж, бие биеэсээ суралцан хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан.</p> <p>Хүрсэн түвшин: 196</p>	
1.4.9	ЕБС-ийн багш нарын дунд “Сайн хичээл үйл ажиллагаа”, СӨБ-ын багш нарын дунд “Бүтээлч багш” аяныг зохион явуулж, түгээн дэлгэрүүлнэ	Сургуулийн төсөв 10.0 сая	Хамрагдсан багшийн тоо	ЕБС-0, СӨБ-0	Эхний хагас жилд: ЕБС-110, СӨБ-24 Жилийн эцэст: ЕБС-165, СӨБ-57	“Сайн хичээл-үйл ажиллагаа” багш нарын хичээл заах, туршлгаа бусдад түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг аймгийн 44 сургуулийг 5 бүсэд хуваан бүх судлагдахууны хичээлээр болон бага ангийн монгол хэл, казах хэл, математик, байгаль ухааны хичээлүүдээр	100%

						явуулж, 112 багш хамрагдсан. Багш нарын хичээлийн хэлэлцүүлэгт бүс бүсээс очсон менежер, захирлууд болон БШУГ-ын мэргэжилтнүүд оролцож, хөтөлбөрийн сайжруулалтад анхаарах асуудлыг хэлэлцэж, зөвлөгөө өгсөн. СӨБ-ын багш нарын дунд “Бүтээлч багш” аяныг Намар зохион байгуулахаар төлөвлөсөн Хүрсэн түвшин: ЕБС-112 Хавсралт: 2 файл	
1.5.	Удирдлагын менежментийг сайжруулна	0	Чадахуйн зарчимаар томилогдсон хүний тоо	Чадахуйн зарчимаар томилогдсон хүний тоо-7	Чадахуйн зарчимаар томилогдсон хүний тоо-17	Удирдлагын менежментийг сайжруулах зорилтын хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөгдснөөс 97.1%-тай байна.	97.1%
1.5.1	Ерөнхий боловсролын сургуульд захирал, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, багш сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод зохион байгуулах, чадахуйн зарчмаар томилно	0	Чадахуйн зарчим баримтлах	17	Эхний хагас жилд: 3 Жилийн эцэст: 10	1. Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, Буянт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал, Өлгий сумын 6, 22 дугаар цэцэрлэг, Дэлүүн сумын 3, Улаанхус сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 133 дугаар албан бичгээр, мөн шинээр байгуулагдсан Өлгий	100%

					<p>сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургууль, Ногооннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирал, Өлгий сумын 26, 27, 32 дугаар цэцэрлэг, Алтай сумын хүүхдийн 2, Бугат сумын хүүхдийн 3, Толбо сумын хүүхдийн 2, Улаанхус сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч, Өлгий сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургууль, Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирлын албан тушаалын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 288 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>2. 2024 оны хагас жилийн байдлаар Цэнгэл сумын ерөнхий боловсролын 2, 3, 4 дүгээр сургуулиудаас англи хэл, түүх, нийгмийн ухаан, бага ангийн багш, Өлгий сумын ерөнхий боловсролын 7 дугаар сургуульд бага ангийн багш, Толбо сумын ерөнхий боловсролын сургуульд мэдээлэл технологийн багш, Сагсай сумын ерөнхий</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>боловсролын сургуульд дизайн технологийн багш нарын сул орон тоо гарч, БШУГ-аас сонгон шалгаруулалтыг тус тус зохион байгуулсан.</p> <p>Хүрсэн түвшин: 17</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.5.2	Боловсролын салбарын удирдах ажилтнуудын чадавхыг дээшлүүлэн, ажлыг дүгнэж, урамшуулах, хариуцлага тооцох	0	Хамрагдах удирдах ажилтнуудын тоо	Захирал-39, Эрхлэгч-51	Эхний хагас жилд: Захирал-39, Эрхлэгч-51 Жилийн эцэст: Захирал-39, Эрхлэгч-51	<p>Ерөнхий боловсролын сургуулийн 44 захирал, 57 цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны жилийн эцсийн тайланг авч дүгнэн, 2024 оны гүйцэтгэлтийн төлөвлөгөөнд тусгах ажлуудын чиглэл өгч, нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан ба хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулан сургууль, цэцэрлэг бүрд зайлшгүй сайжруулах ажлуудын үзүүлэлтийг тусгаж, гэрээ байгуулсан болно. Сургуулийн захирал, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нарын ажлын 2023 оны ажлын үр дүнг дүгнэж, хангалттай үнэлэгдсэн, сахилгын шийтгэл хүлээгээгүй 12 сургуулийн захирал, 24 цэцэрлэгийн эрхлэгчдэд Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/22</p>	100%

					<p>дугаар тушаалаар ур чадварын нэмэгдэл олгосон. Ажлын хариуцлага алдаж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасныг зөрчсөн Өлгий сумын ерөнхий боловсролын 3, Цэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захиралд хариуцлага тооцож, албан тушаалын цалингийн хэмжээг нэг сар 30 хувиар бууруулсан. Мөн хариуцсан үүрэгт ажлаа салгардуулан, үүргээ хангалтгүй гүйцэтгэж, сургууль нь 2022-2023 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад улсын дунджаас 149.9, аймгийн дунджаас 122.7 оноогоор тус тус доогуур, 10 хичээлийн дундаж оноо 366.8 болж, аймгийн хэмжээний 24 сургуулиас хамгийн доогуур үзүүлэлттэй гарсан Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн захиралд нээлттэй сануулах сахилгын</p>
--	--	--	--	--	---

						<p>шийтгэл ногдуулсан. Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах үед ажилдаа хайхрамжгүй хандаж, өөрийн хариуцсан үүрэгт ажлаа цалгардуулан, хариуцлагагүй ажилласан Өлгий сумын хүүхдийн 3, 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч, Өлгий сумын ерөнхий боловсролын 1, 6, 9 дүгээр сургуулийн захирал нарт тус тус нээлттэй сануулах сахилгын шийтгэл ногдуулсан.</p> <p>Хүрсэн түвшин: Захирал-39, Эрхлэгч-51</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.5.3	Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн менежментийг сайжруулах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөн тусална	Орон нутаг, БШУГ-ын төсөв	Зөвлөн тусалсан байгууллагын тоо	110	Эхний хагас жилд: 65 Жилийн эцэст: 125	Менежментийг сайжруулах зорилтод сургуульд сонгогдсон Буянт, Бугат, Улаанхус сумын Согоог багийн ЕБС, Цагааннуур тосгоны 9 жилийн сургууль, Өлгий сумын 1, 5, 7, 10 дугаар сургуулиудын удирлага, багш нартай цахим болон танхимаар 2 удаагийн уулзалтыг зохион явуулж, 2023 оны тайлан, сургуулийн өөрийн үнэлгээнд дүн шинжилгээ	100%

					<p>хийж, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах ажлуудыг боловсруулах талаар арга зүйчидтэй хамтран ажилласан. Дээрх 8 сургуульд ажиллах арга зүйчдийг хуваарилан өөр өөрсдийн хариуцсан сургуулийн мэдээллийг бэлтгэн, цаашид тулгамдаж буй асуудлыг тодорхойлон БЕГ-аас ирсэн ажлын хэсэгт танилцуулж, хамтран ажилласан. Уг ажлын хэсэгтэй хамтран Бугат сумын ЕБ-ын сургууль, Өлгий сумын 1 дүгээр сургуульд удидамжийн дагуу зөвлөн туслаж ажилласан. Булган сумын Сөнхөл багийн ерөнхий боловсролын сургуульд БШУГазрын даргын удирдамжийн дагуу ажиллаж, менежмент, сургалтын үйл ажиллагааг сайжруулах талаар, арга зүйн дэмжлэг үзүүлэн, дүгнэлт гаргасан. Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг байгуулах чиглэл өгснөөр бүх сургалтын байгууллагууд зөвлөлөө байгуулсан. Сургуулийн нэршил өөрчлөгдсөнтэй холбоотой сургуулиуд</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>хаяг, тусгай зөвшөөрлөө шинэчилсэн.</p> <p>Хүрсэн түвшин: 65</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.5.4	<p>Арга зүйч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, гадаад болон дотоодод туршлага судлуулна</p>	10.0 сая	Мэргэжилтний тоо	7	<p>Эхний хагас жилд: 10</p> <p>Жилийн эцэст: 22</p>	<p>Хагас жилийн байдлаар УБ хотод болсон сургалтад 2 арга зүйч, “Боловсролын хувирган өөрчлөлт” чуулганд 3 мэргэжилтэн оролцож, мэдлэг, боловсролоо дээшлүүлсэн. Оросын Холбооны Улсын Горно-Алтай хотод болох эрдэм шинжилгээний бага хуралд гадаад хэлний арга зүйч, Казахстан улсын Алма-Ата хотод болох туршлага солилцох уулзалт, сургалтад казах хэлний арга зүйч оролцож байна. Казахстан улсын Алма-Ата хотын Аль-Фарабийн нэрэмжит Улсын Их сургуульд “Устөрөгчийг уснаас катализаторын тусламжтайгаар гарган авах” сэдвээр хими, биологийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч докторын зэрэг хамгаалсан. Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар, Дотоод аудитын хэлтэсээс зохион байгуулсан БШУГ-ын төсвийн төлөвлөлт,</p>	100%

						гүйцэтгэл зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, статистик мэдээлэл хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад 2 мэргэжилтэн хамрагдав. Хүрсэн түвшин: 10 Хавсралт: 5 файл	
1.5.5	Шаардлага хангасан төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох, албан тушаалын зэрэглэлийг ахиулах арга хэмжээ авах	0	Албан хаагчийн тоо	3	Эхний хагас жилд: 5 Жилийн эцэст: 5	1. “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.4, 2.5-д заасны дагуу 2023 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин хангалттай үнэлэгдсэн, хугацааны шалгуур хангасан төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг ахиулах талаар 2 мэргэжилтний материалыг танилцуулгын хамт Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2024 оны 02-р сарын 29-ний өдрийн 134 тоот албан бичгээр аймгийн ЗДТГ-т, БШУГ-ын даргын материалыг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 147 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, шинжлэх ухааны яамны	100%

						<p>дэргэдэх салбар зөвлөлд тус тус хүргүүлж, аймгийн Засаг даргын 2024 оны 04-р сарын А/294 дүгээр захирамжаар 2 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг 5-р сарын 1-ээс эхлэн олгож байна. 2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Бүтэц, орон тоо батлах тухай” А/137 дугаар тушаалаар тус байгууллагын бүтэц шинэчлэн батлагдан, бүх арга зүйч нарын албан тушаалын зэрэглэл өөрчлөгдөж, ахлах арга зүйч болсонтой холбогдуулан ахлах арга зүйчээр 11 хүнийг томилохоор хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, 2024 оны 06-р сарын 01-ний өдрөөс эхлэн ахлах арга зүйчээр томилон ажиллуулж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 12</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.5.6	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар жилд хоёроос доошгүй удаа тухайн орон нутгийн боловсролын асуудлыг хэлэлцүүлж, гарсан үр дүнгийн дагуу	Орон нутгийн төсөв	Боловсролын салбартай холбоотой гарсан шийдвэрийн тоо	8	Эхний хагас жилд: 8 Жилийн эцэст: 10	1. БШУГ-ын цонх солих, хаяг хийлгэх, тавилга шинэчлэх асуудлаар 2024 оны эхний хагас жилд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 2 удаа бичгээр хүсэлт	100%

	арга хэмжээ авна					<p>оруулж, 27.7 сая төгрөг шийдвэрлүүлэв. 2. Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын дунд 2023-2024 оны хичээлийн жилийн Улсын төрөлжсөн олимпиадын II давааг зохион байгуулахаар БШУЯ-аас шийдвэр гарч, Боловсролын ерөнхий газраас 4.5 сая төгрөгийг шийдвэрлэж өгсөн ба нэмэлт шаардлагатай 2.3 сая төгрөгийн хөрөнгийн тооцоог гарган, аймгийн Засаг даргад бичгээр хүсэлт тавьж, шийдвэрлүүлэв. 3. Хос хэлээр сургалт явуулдаг сургуулиудын монгол хэлний хичээлийн дасгал ажлын дэвтэрийг хэвлүүлэх зардал болох 60.0 сая төгрөгийг орон нутгаас шийдвэрлэж өгөхийг аймгийн Засаг даргад саналаа оруулсан.</p> <p>Хүрсэн түвшин: 8</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.5.7	Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн хангалтгүй байгаа цэцэрлэг, сургуулийн менежементийг сайжруулах, үйл	0	Арга хэмжээний тоо	8	Эхний хагас жилд: 8 Жилийн эцэст: 11	Сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвийн 3 цэцэрлэг, 5 сургууль, хөдөө сумын 3 сургууль,	100%

	ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, багш нарыг сургах, мэргэжлийн бүлгээр ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ					өнгөрсөн хичээлийн жилд уг хөтөлбөрт хамрагдсан 4 сургууль нийтдээ 3 цэцэрлэг, 12 сургуулийн менежментийг сайжруулах үйл ажиллагаа хуваарийн дагуу явагдаж байна. Хүрсэн түвшин: 8 Хавсралт: 9 файл	
1.6.	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	85.5 сая	Арга хэмжээний тоо, дундаж оноо, хамрагдсан багш, сурагчийн тоо	Арга хэмжээний тоо-0-6 дундаж оноо-480 хамрагдсан багшийн тоо-500-1000 сурагчийн тоо-50-200	Арга хэмжээний тоо-0-6 дундаж оноо-500 хамрагдсан багшийн-1000-1500 сурагчийн тоо-50-300	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 15 арга хэмжээ төлөвлснөөс биелэлт 92.6%-тай байна. Зарим хөтөлбөрийн төлөвлгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн санхүүжилт нь орон нутгаас шийдэгдээгүйн улмаас төлөвлөгдсөн хугацаанд биелэгдээгүй болно.	92.6%
1.6.2	“Сургуулийн хөгжил-Багшийн хөгжил-Сургалтын чанар” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	Орон нутгийн төсөв	Хөтөлбөр хэрэгжсэн байна	50%	Эхний хагас жилд: 60% Жилийн эцэст: 100%	Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн хэлний чадварыг сайжруулах, орос хэлний багш нарын ээлжит хичээлийг заахад дэмжлэг үзүүлэх үүднээс ОХУ-ын Горно-Алтайн Улсын их сургуулийн 3 багш ерөнхий боловсролын 3, 4 дүгээр сургуульд 2 долоо хоног ажилласан. Тус сургуулийн	100%

						<p>орос хэлний багш нартай хамтран хичээл зааж, харилцан туршлага судалсан. Багш нар Горно-Алтай мужийн ерөнхий боловсролын сургуулиудын туршлага судалсан. Тус мужийн 12 сайн дурын ажилтан Өлгий сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль, Алтанцөгц, Бугат, Дэлүүн сумын ЕБ-ын сургуулийн сурагчдад 14 хоногийн сургалт явууллаа.</p> <p>Хүрсэн түвшин: 60%</p> <p>Хавсралт: 2 файл</p>	
1.6.3	“Эх хэлээ эрхэмлэе” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана	Орон нутгийн төсөв	Хөтөлбөр хэрэгжсэн байна	90%	Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 100?%	<p>1. “Эх хэлээ эрхэмлэе” дэд хөтөлбөрийн хүрээнд /казах хэл/: 1.1. “Казах хэлний багш нарын монгол хэлний ярианы чадварыг сайжруулах” сургалтыг 2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж, нийт 40 багшийг хамруулсан. 1.2. Казах хэлний зарим зөв бичих дүрмийн талаар “Зөв бичихэд тус дэм” сургалтад 178 багш нар болон байгууллагуудын ажилтан, албан хаагчид хамрагдсан. 1.3. Аймгийн хэмжээний казах хэл, уран зохиолын олимпиад 2024 оны 1 дүгээр сарын 25-26-</p>	100%

					<p>ны өдрүүдэд 10-12 дугаар ангийн сурагч, мэргэжлийн багш нарын дунд зохион байгуулагдаж, 31 багш, 66 сурагч хамрагдсан. 1.4. “Оны шилдэг казах хэл, уран зохиолын багш” уралдааныг “Монголын казахуудын хэл, соёлыг дэмжих холбоо”-той хамтран зохион байгуулсан. 1.5. Боловсролын ерөнхий газар, Казахстан улсын багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх үндэсний “Өрлеу” төвтэй хамтран казах хэл, уран зохиолын багш нарын онол, арга зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх, эх хэлний сургалтын идэвхтэй арга, аргачлал, мөн суралцагчдын эх хэлний мэдлэг чадварыг үнэлэх арга аргачлалд суралцуулах зорилготой сургалтыг 05 дугаар сарын 20-ний өдрөөс 05 дугаар сарын 22-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулж, 52 багш хамрагдлаа. 1.6. “Номтой нөхөрлөө” сэдэвт уралдааныг хөтөлбөрийн дагуу 4 үе шатаар зохион байгуулсан. Уг уралдаанд сургууль бүрээс нэг баг, нийт 27 сурагч</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>хамрагдлаа. 2. “Эх хэлээ эрхэмлэе” дэд хөтөлбөрийн хүрээнд /монгол хэл/: 2.1. Аймгийн нийт сургуулийн монгол хэлний багш нарын дунд ур чадварын уралдааныг Өлгий сумын 1 дүгээр сургуульд зохион байгуулж, 28 багш оролцон, мэргэжлийн багш нарт арга зүйгээ түгээн дэлгэрүүлж, туршлагаасаа хуваалцлаа.</p> <p>Хүрсэн түвшин: 80%</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.6.4	“Эко сургууль” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	Орон нутгийн төсөв	Хөтөлбөр хэрэгжсэн байна	50%	Эхний хагас жилд: 60% Жилийн эцэст: 100%	<p>“Эко сургууль” дэд хөтөлбөрт 10 сургууль олон улсын хөтөлбөрийн 3 дахь шатны сургалтад 2024 оны 05-р сарын 16,17-ны өдрүүдэд хамрагдаж, УБ хотоос ирсэн сургагч багш нар сургалтыг зохион явуулсан. Сургалтад 10 сургууль тус бүрээс сургуулийн удирдлага-2, багш-3, сурагч-5 нийт 95 хүн хамрагдсан. Эко сургуулийн багш нарт 1 удаагийн онлайн сургалт, эко зөвлөлийн сурагчдад танхимын 1 өдрийн сургалтыг БОАЖГ, БШУГ хамтран зохион байгуулсан. БОАЖГ, НТБ,</p>	80%

						<p>БШУГ хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 9-12-р ангийн сурагчдын дунд "Ус-чандмань эрдэнэ" сэдэвт эсээ бичих уралдаанд 35 сурагч оролцсон. Ерөнхий боловсролын сургуулийн 5-8-р ангийн сурагчдын дунд "Бидний бүтээх ногоон ирээдүй" сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулсан ба 25ш бүтээл ирсэн.</p> <p>Хүрсэн түвшин: 50%</p> <p>Хавсралт: 2 файл</p>	
1.6.5	“Дотуур байр-миний гэр” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	Орон нутгийн төсөв	Хөтөлбөр хэрэгжсэн байна	85%	Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 100%	<p>Дотуур байранд амьдарч буй хүүхдэд хамгааллын үйлчилгээг тасралтгүй үзүүлэх, дотуур байрын багш, анги удирдсан багш, эцэг эх, суралцагчдын хамтын ажиллагааг дээшлүүлэх, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын хэрэгжилтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор дотуур байрны 104 багшийг хамруулж сургалт зохион байгуулсан.</p> <p>Дотуур байруудад орчны судалгааг хагас, бүтэн жилийн байдлаар 2 удаа хийсэн. Судалгааг үндэслэж дотуур байр бүр тулгамдсан 10 асуудлыг</p>	90%

						<p>гаргаж, хамтарсан баг төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу ажилласан. Судалгаанаас харахад дотуур байруудад материаллаг бааз дутмаг, орчны үнэлгээ доогуур үнэлгээтэй байсан. Дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах, багш ажилтнуудыг чадавхжуулах замаар дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаануудыг тогмол зохион байгуулж байна. Сум, сургуулийн дотуур байрын багш, нийгмийн ажилтнуудын сайн туршлагуудаа бусад сум сургуулиудад түгээх, бие биэнээсээ суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор уг ажлыг намар зохион байгуулахаар төлөвлөж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 70%</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.6.6	“СӨБ-Хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	дэд	Орон нутгийн төсөв	Хөтөлбөр хэрэгжсэн байна	85%	<p>Эхний хагас жилд: 90% Жилийн эцэст: 100%</p> <p>2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанарыг</p>	100%

						<p>сайжруулах зорилгоор аймгийн сургуулийн өмнөх боловсролын сургалт үйл ажиллагааны жишиг төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж, нийт цэцэрлэгүүдэд хүргүүлэн, хүүхдийн авьяас чадварыг илрүүлэн, хүүхэд бүрийг хөгжүүлэхэд хүүхдийн цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд хөгжмийн энгийн зэмсэг сургах, спорт өрөлт, дүрс бүтээх, бүжиг, даам, шатрын дугайлан ажиллуулж, 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг ханган нэмэлт төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжиж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 90%</p> <p>Хавсралт: 2 файл</p>	
1.6.7	“Хүүхэд хөгжил, хүмүүжил, хамгаалал” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	Орон нутгийн төсөв	Хөтөлбөр хэрэгжсэн байна	70%	Эхний хагас жилд: 70% Жилийн эцэст: 100%	<p>1.Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран бие махбодын хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, сэтгэл зүйн хүчирхийлэл, үл хайхрах хүчирхийллийн талаар сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 554 хүүхдийг хамруулсан.</p> <p>2.Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтантай хамтарч</p>	100%

					<p>“Хүүхдийн эрх ба хүүхэд хамгаалал” сэдвээр зохион байгуулсан сургалтад 1890 эцэг эх, асран хамгаалагч оролцсон. 3.Гэмт хэрэг, хор уршиг, оногдуулах ял шийтгэл, түүний хор уршгийн талаар богино хэмжээний шторк хийж, ЕБ-ын сургуулиудын пейж хуудсанд байршуулан эцэг эх, асран хамгаалагчдад түгээж ажилласан.</p> <p>4.Аймгийн төвийн 1,2,3,4,5,6-р сургуулиудад гэмт хэрэг , хүчирхийлэл түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гаргасан хүүхэд, түүний эцэг, эх асран хамгаалагч нарт хамтран ажиллах талаар зөвлөмж хүргүүлж, энэ талаар тодорхой ажил зохион байгуулж түүний үр дүнг хүргүүлэх тал дээр хамтран ажилласан. 5. Аймгийн ЗДТГ, ГБХХХГ-тай хамтран шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сүм хийд болон төрийн бус байгууллагын дэргэдэх дотуур байруудад амьдарч буй хүүхдийн Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгах, хүүхдүүдийн</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. 6. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг сургууль болон цахим орчинд дарамт, дээрэлхэлтээс сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мэдлэг олгох, багаар хамтран ажиллах, бүтээлч шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга зүйд суралцах сургалтыг сургуулийн нийгмийн ажилтнуудад цахимаар 2 удаа зохион байгуулсан. 7. “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж 8978 хүүхдийг хамруулсан. 8. Аймгийн ЗДТГ, ГБХХГ-тай хамтарч “ Хүүхдийн эрхийг дээдэлье” хүүхдийн чуулганыг зохион байгуулж сумдын сургуулиудын сурагч, багш, эцэг эхийн төлөөллүүд нийт 534 хүн оролцсон. Энэ нь хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхдийн дуу хоолой, үзэл бодлыг с</p> <p>Хүрсэн түвшин: 70%</p>	
--	--	--	--	--	--	--

						Хавсралт: 1 файл	
1.6.8	“Тэгш хамран сургалт-тэгш хүртээмжит боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	Орон нутгийн төсөв, ОУБ	Хөтөлбөр хэрэгжсэн байна	70%	Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 100%	Норвегийн тусламжийн байгууллага, Насан туршийн боловсролын төвтэй хамтран Ногооннуур сумын 1, 4 дүгээр сургууль, Цагааннуур тосгоны 9 жилийн сургууль, Улаанхус сумын 1, 3 дугаар сургуулиудад 2024.03.10-15 ны өдрүүдэд ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт, хамрагдаагүй шалтгаан, багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн ажиллаж байгаа байдал, сургуулийн дэмжлэгийн багийн үйл ажиллагаатай танилцаж, нөхцөл байдлыг сумдын Засаг дарга нарт танилцуулан, цаашид шийдэх асуудлыг холбогдох байгууллагад хамтран ажиллах талаар харилцан санал бодлоо солилцож, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Хүрсэн түвшин: 80%	100%
						Хавсралт: 3 файл	
1.6.9	Бичиг үсгийн боловсрол олгох, боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг	Орон нутгийн	Хамрагдсан хүүхдийн тоо	322	Эхний хагас жилд: 299 Жилийн эцэст:	Бичиг үсгийн боловсрол олгох, боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр 2023-	100%

	мэргэжлийн багш нараар хичээл оруулж, чанар, хүртээмжийг сайжруулна	төсөв			299	2024 оны хичээлийн жилд анхан, дунд, гүнзгий, сургалтын дараах шатны сургалтанд 207 хүн бүртгүүлэн суралцаж байна. Монгол хэлний хэрэглээ, хөгжил, бүх нийтийн бичиг үсгийн боловсролын түвшинг судалж, үнэлж дүгнэх үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 04 сарын 26-ны 165 дугаар тогтоолын дагуу Аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөлт гаргасан. Хүрсэн түвшин: 207	
1.6.10	Улс, олон улс, бүс, төрөлжсөн, нэрэмжит олимпиадыг зохион явуулах, олимпиадад оролцоход дэмжлэг үзүүлнэ	БЕГ, Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо	6	Эхний хагас жилд: 3 Жилийн эцэст: 6	Улсын төрөлжсөн олимпиадыг журам, хуваарийн дагуу хугацаанд нь зохион байгуулж, хичээлийн 14 төрлөөр явагдаж, 650 гаруй багш, 1200 гаруй сурагч оролцож, түрүүлсэн багш, сурагчдыг урамшуулан, 3-ын даваанд оролцуулах бэлтгэл ажлын ханган ажиллаж байна. Увс аймгийн Өмнөговь сумд зохиогдсон “Баруун бүсийн физикийн олимпиад”-д багш сурагчид амжилттай оролцож, 1 алт, 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртлээ. Улсын төрөлжсөн	100%

					<p>олимпиадын 3-ын даваанд химийн XXXIII олимпиадад ерөнхий боловсролын Зайд сургуулийн 9-р ангийн сурагч амжилттай оролцож III байр эзэлсэн. Монгол хэл бичгийн улсын 53 дугаар олимпиадад оролцсон багш X байр, сурагч IX байр эзэлсэн болно. Монгол бичгийн улсын XVIII олимпиадад оролцсон сурагч тусгай байр эзэлсэн. Үндэсний бичгийн Улсын тэргүүний уншигч уралдаанд оролцсон сурагч “Шилдэг уншигч”-аар шалгарсан. Казахстан улсын Ахтау хотод 2024 оны 6 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулагдах Казах хэл, уран зохиолын Олон Улсын XXI олимпиадад оролцогчдыг мэдээллээр хангаж, бэлтгэл ажлыг хийж байна. МУБИС-ийн ДУТС-иас зохион байгуулсан улсын зураг зүйн мэргэжлийн олимпиадад ЕБ-ын 4 дүгээр сургуулийн сурагч амжилттай оролцож, Шинжлэх ухааны доктор, профессор, Монгол улсын Ардын багш, академич А.Мекейн нэрэмжит математикийн НЭЭЛТТЭЙ IX дүгээр олимпиадад</p>	
--	--	--	--	--	--	--

						Баян-Өлгий аймгийн I дүгээр баг III дугаар байр эзэлсэн. Хүрсэн түвшин: 3 Хавсралт: 9 файл		
1.6.11	Сургуулийн боловсролын үйлчилгээний сайжруулан, авьяасыг хөгжүүлж, дэлгэрүүлнэ	өмнөх чанарыг хүүхдийн илрүүлэн түгээн	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо	5	Эхний хагас жилд: 4 Жилийн эцэст: 5	Сургуулийн боловсролын үйлчилгээний чанарыг зорилгоор сургалт үйл ажиллагааны жишиг төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж, нийт цэцэрлэгүүдэд хүргүүлэн, хүүхдийн авьяас чадварыг илрүүлэн, хүүхэд бүрийг хөгжүүлэхэд ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд хөгжмийн энгийн зэмсэг сургах, спорт өрөлт, дүрс бүтээх, бүжиг, даам, шатрын дугуйлан хичээллүүлсэн. Хүүхдийн авьяасыг илрүүлэн хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор давхардсан тоогоор шатрын 300, даамны 1000 эв, долоодойгоор 1300, спортын төрлөөр 800, дууны 1000, бүжгийн 1200, бусад 1500 гаруй хүүхдийг дугуйланд хамруулж, 7100 хүүхэдэд түгээн дэлгэрүүлсэн болно. Хүрсэн түвшин: 3	80%

1.6.12	Хөндлөнгийн үнэлгээний шалгалт зохион байгуулах, дүн шинжилгээ хийнэ	Орон нутгийн төсөв	Шалгалтын тоо	3	Эхний хагас жилд: 5 Жилийн эцэст: 8	БШУГ-ын даргын удирдамжийн дагуу Цэнгэл 1, 2, 3, 4, Булган сумын 1, 2, 3, Улаанхус 1, 2, 3 сургуулиуд дээр ажиллахад зарим ангиудаас сургалтын хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж, багш нараас шалгалт авч, дүнд дүн шинжилгээ хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Аймгийн хэмжээний 12 дугаар ангиудаас ЭЕШ-ын 10 хичээл дээр 3 удаа хөндлөнгийн шалгалт авч, дүн шинжилгээ хийж, сургуулиудад хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд сургалт явуулж байгаа 6 хувийн сургуульд БШУСайдын 2024 оны А/64 тушаалын хавсралтаар баталсан шалгуурын дагуу хяналт шинжилгээ хийж, сургууль бүрээр үнэлгээг гаргаж, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж гаргаж ажилласан. Хүрсэн түвшин: 10 Хавсралт: 2 файл	100%
1.6.13	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчин дахь хүүхэд хамгааллын асуудалд онцгойлон анхаарч,	Орон нутгийн төсөв	Сурагчдын тоо	500	Эхний хагас жилд: 300 Жилийн эцэст: 600	1. "Сургуулийн нийгмийн ажлын мэргэжил"сэдэвт сургалтыг зохион байгуулж, ЕБС-ийн 33 нийгмийн ажилтныг	100%

	<p>сургууль, дотуур байрны орчинд хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр компанит, нөлөөллийн ажлыг олон талт хэлбэрээр зохион байгуулах, зөвлөгөө мэдээлэл авах нээлттэй утас байршуулна</p>					<p>хамруулсан. Сургуулийн нийгмийн ажилтнуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хүүхдийг хамгаалах чиглэлээр мэдээлэл өгсөн. 2. “Дэлхийн нийгмийн ажилтнуудын өдөрлөг”-ийг тохиолдуулан ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудын өдөрлөгийг зохион байгуулж, ЕБС-ийн 33 нийгмийн ажилтан хамрагдсан. Баг, сум, аймгийн нийгмийн ажилтнуудын хамтын ажиллагааг сайжруулах, туршлага солилцох ажил мэргэжлийн уялдаа холбоог нэмэгдүүлэн, хамтран ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн залуу, дунд, ахмад үеийн нийгмийн ажилтнууд хоорондоо сайн туршлагаасаа хуваалцаж, санал солилцов.</p> <p>Хүрсэн түвшин: 330</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
1.6.14	<p>Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх, тэдэнд холбогдох хууль</p>	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо	8	Эхний хагас жилд: 4 Жилийн эцэст: 6	Захирал, эрхлэгч нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт хууль, журмын дагуу нэмэгдэл олгох талаар албан бичиг хүргүүлсэн ба сургалтын	80%

ТОГТООМЖИД нэмэгдэл, урамшуулал заасан олгоно					<p>үеэр эрх зүйн баримт бичгүүдийг танилцуулан, олгохгүй байгаа удирдлагуудад онцгойлон анхааруулснаар нэмэгдлийг бүрэн олгож байгаа. Тэгш хамрагдалтын нөхцөл байдалтай танилцах, мониторингийн ажлын хэсэг 2 өдөр аймгийн төвийн 4 дүгээр цэцэрлэг, 2 дугаар сургуульд ажиллаж, сургууль, цэцэрлэгийн нийт 102 багшид чадавхжуулах сургалт зохион байгуулж, зөвлөн туслаж ажилласан. Аймгийн хэмжээний сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн судалгааг гарган, нийт 2-6 насны хөгжлийн бэрхшээлтэй 185 хүүхдээс 65 хүүхэд буюу 35.4% нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг өдрийн бүлэг, явуулын багшийн үйлчилгээг авч байна. ХБХ-тэй ажиллаж байгаа багш на, цэцэрлэгийн дэмжлэгийн багийн ахлагч гишүүдэд 2024 оны 01 дүгээр сараас дараах сургалтуудыг зохион байгуулсан болно. Үүнд: ХБХ-тэй ажиллаж байгаа багш нар болон дэмжлэгийн</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>багийн гишүүдийг Баруун таван аймгийг хамруулсан БЕГ, Жайка, Старт-2 төслөөс зохион байгуулсан тэгш хамрагдалтын туршлага солилцоо мониторингийн сургалт 2023.11.27-12.01. Тусгай хэрэгцээт хүүхдийн сэтгэл зүй” сургалт “Энэрэлийн түүчээ” ТББ -д танхимаар зохион байгуулсан 2023.12.12. - “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн онцлог шинж, хэрэгцээнд нийцүүлсэн асран хамгаалах, хөгжүүлэх загвар, арга зүй” сургалт Норвегийн Тусламжийн байгууллага танхим 2024.12.15 Аймгийн сургуулийн өмнөх боловсрол тэгш хамран сургах боловсролыг хариуцан ажиллаж байгаа СӨБ-ын МХБ Баянзүрх дүүргийн 10, 186 дугаар тусгай хэрэгцээт цэцэрлэгүүдийн туршлагаасаа суралцаж хамтран ажилласан. БШУГ, ГБХХХГ-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүтээлийн үзэсгэлэн”-г аймгийн нийт ЕБ-ын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж,</p>
--	--	--	--	--	---

						үзэсгэлэнд 15 сургуулийн 21 сурагч оролцсон болно. Хүрсэн түвшин: 3 Хавсралт: 1 файл	
1.6.15	Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан, албан хаагч нарыг чадваржуулах сургалт зохион байгуулна	Орон нутгийн төсөв	Оролцогчдын хувь	60%	Эхний хагас жилд: 60% Жилийн эцэст: 80%	2024 онд нийт 10 сургууль, 3 хүүхдийн цэцэрлэг хоол зүйчийн орон тоо батлуулж, ажиллуулж эхэлсэн. Үүнээс 2 хоол зүйч хөрвөх сургалтад хамрагдаж байна. Аймгийн ХХААГ-тай хамтарч сургууль, цэцэрлэгийн тогооч нарыг "Хүнсний аюулгүй байдал" аянд хамруулав. Хүнсний аюулгүй байдал аяны хүрээнд ХХААГ, БШУГ, МЭГ, ЭМГ, ЕБ-ын 3 дугаар сургууль хамтран аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн 51 эмч, хоол зүйч, нярав, тогооч нарт "Хүнсний аюулгүй байдлыг хангах нь" сэдэвт сургалт зохион байгуулав. Хүрсэн түвшин: 60%	100%
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
3.1.	Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ	0	Хамрагдалтын хувь, тоо, тайлбар	СӨБ хамрагдалт- 84.5%, ЕБ-ын хамран сургалтын хамрагдалт-	СӨБ хамрагдалт- 87.0%, ЕБ-ын хамран сургалтын хамрагдалт-	Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх зорилтын хүрээнд 11 арга хэмжээ	100%

				93%, 5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт-97.1%, 6 настай хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт-71.1% Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдсан тоо- 266	94.5%, 5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт-100%, 6 настай хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт-73%, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдсан тоо- 280	5 төлөвлөгдөж, 100% биелэгдсэн байна.	
3.1.1	Ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ	0	Хамрагдалтын хувь	ЕБС-93%, СӨБ-84.5%	Эхний хагас жилд: ЕБС-93%, СӨБ-85.0% Жилийн эцэст: ЕБС-94.5%, СӨБ-87.0%	Цэцэрлэгт хамрагдаагүй сургуулийн өмнөх насны хүүхдийн судалгааг гарган, шинэ цэцэрлэг байгуулах, салбар бүлэг нэмж ажиллуулах талаар саналаа аймгийн Засаг даргад хүргэн ажиллаж байна. Сүүлийн 4 жилийн хүүхдийн цэцэрлэгийн хамрагдалт сумаар нь судалгаанаас харахад хамрагдалт хамгийн бага байгаа Баяннуур, Алтанцөгц, Булган, Буянт, Ногооннуур сумууд бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд Баяннуур, Алтанцөгц,	100%

						<p>Ногооннуур суманд шинээр цэцэрлэг байгуулсан. Энэ хичээлийн жилийн байдлаар СӨБ-ын хамрагдалт 84.5%, ЕБС суурь боловсролын буюу 6-14 насны хүүхдийн хамрагдалтын цэвэр жин 93.3 хувь байна. Өмнөх онтой харьцуулахад хүүхдийн тоо аймгийн төвд 477 хүүхдээр нэмэгдсэн бол сумдад 73 хүүхдээр буурсан нь хүн амын өсөлт болон шилжих хөдөлгөөнтэй холбоотой байна. 2024 оны хамрагдалт энэ оны 10 дугаар сард гарна.</p> <p>Хүрсэн түвшин: ЕБС-93%, СӨБ-84.5%</p> <p>Хавсралт: 2 файл</p>	
3.1.3	5 настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулж, 6 настай хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлнэ	0	Хамрагдалтын хувь	5 нас- 97.1%, 6 нас-71.1%	<p>Эхний хагас жилд: 5 нас- 98.5%, 6 нас- 71.5%</p> <p>Жилийн эцэст: 5 нас- 100%, 6 нас- 73%</p>	<p>БШУЯ-ны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргын 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн “5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулах тухай” 15/3571 тоот албан бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор БШУГ-ын даргын 5 настай хүүхэд бүрийг сургуулийн</p>	100%

					<p>өмнөх боловсролд хамруулах албан бичгийг цэцэрлэгүүдэд хүргүүлэн, цэцэрлэгийн эрхлэгч нарт баг бүрдэж ажиллах үүрэг чиглэл өгч ажилласны үр дүнд нийт 5 настай хүүхдийн хамрагдалтыг тухайн хичээлийн жилд 90.4%-д хүргэж, өмнөх жилээс 4.3 хувиар ахиулсан. 6 настай хүүхдийн хамрагдалт 71.1 хувьтай болж өмнөх оноос 1.8 хувиар ахисан байгаа. 6 настай хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх үүднээс Сумын Засаг дарга болон сургуулийн захирлуудын гэрээнд тусгаж өгсөнөөр эцэг эх, асран хамгаалагчидтай уулзалт зохион байгуулж, 6 настай хүүхдийг сургуультай танилцах өдөрлөг зохион байгуулж урилга тарааж өгдөг, дотуур байрууд 6 настай хүүхдийн байрлах өрөөг тохижуулсан ба 5 дугаар ангийн багш нар цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн багш нартай хамтран ажиллаж байна. 2024 оны хамрагдалт энэ оны 10 дугаар сард гарна.</p> <p>Хүрсэн түвшин: 5 нас- 90.4%, 6 нас-71.1%</p>	
--	--	--	--	--	--	--

3.1.4	Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт, боловсролын хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ	0	Шалгалтад хамрагдсан сургууль, цэцэрлэгийн тоо, хяналт, шалгалтын тоо	9, 3	Эхний хагас жилд: 13, 1 Жилийн эцэст: 13, 4	1. Тухайн онд 13 сургалтын байгууллага төлөвлөгөөт шалгалтад хамрагдахаар төлөвлөгдсөнөөс тайлант хугацаанд 11 сургалтын байгууллага төлөвлөгөөт шалгалтад хамрагдаж 7 нь бага, 2 нь дунд, 2 нь их эрсдэлтэй үнэлэгдэж 5 сургалтын байгууллагад зөрчлийг арилгах 68 заалттай хугацаат албан шаардлага хүргүүлсэн. ЭАХХХ-ын улсын байцаагч 2 сургалтын байгууллагад зөрчлийн хэрэг нээж тус бүрийг 500,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан. 2. Түрээсийн байртай сургууль, цэцэрлэгүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийгдэж 1 ЕБС, 4 хүүхдийн цэцэрлэг, 3 хүүхдийн цэцэрлэгийн салбар бүлэг хамрагдаж, 4 цэцэрлэгт зөрчлийг арилгуулах хугацаат албан шаардлага хүргүүлсэн. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын танилцуулгыг хугацаанд БШУ-ны яамд хүргүүлсэн.. Хүрсэн түвшин: 13, 1	100%
3.1.5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бэрхшээлийн	0	Хамрагдалтын тоогоор	266	Эхний хагас жилд: 272	Дэмжлэгийн багийн гишүүдэд 1 удаа	100%

	<p>хэлбэр, нөхцөл байдлаас үл шалтгаалан хамран сургах тойргийн цэцэрлэг, сургуульд хамруулж, танхимын болон хувилбарт сургалтаар боловсролын үйлчилгээ үзүүлэхэд “Боловсролд хамрагдалтын дэмжих зөвлөл”-ийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана</p>				<p>Жилийн эцэст: 280</p>	<p>чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, 38 хүн, цахим сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалт болон хамрагдаагүй шалтгааныг тодруулах зорилгоор Улаанхус сумын 1 дүгээр сургууль, Согоог, Хөх хөтөл багийн ЕБ-ын сургууль, Ногооннуур 1, 2, 3, 4 дүгээр, Цагааннуур тосгоын 9 жилийн сургуулиудад ажиллаж, багш нарын арга зүй, ганцаарчилсан төлөвлөгөөний боловсруулалт, хүүхдийн ахиц, амжилттай танилцаж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.</p> <p>Хүрсэн түвшин: 266</p>	
3.1.6	<p>Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, улсын шалгалт, монгол хэл, бичиг, элсэлтийн ерөнхий шалгалт, чанар болон гүйцэтгэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийх, ажил зохион байгуулах</p>	0	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо</p>	7	<p>Эхний хагас жилд: 5 Жилийн эцэст: 7</p>	<p>БШУГ-аас аймгийн хэмжээний 27 сургуулийн 12 дугаар ангиудын сурагчдаас 3 удаа түвшин тогтоох сорил шалгалт авч, дүн шинжилгээ хийж сургуулиудад хүргэсэн. Сургуулиуд өөрсдөө түвшин тогтоох шалгалт авч, харьцуулж шалгалтын үр дүнг үндэслэн төлөвлөгөө боловсруулан</p>	100%

					<p>ажиллаж байна. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний үр дүнг авч анализ хийж, сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан, багш нарт танилцуулан цаашид авах арга хэмжээний чиглэл, зөвлөмжийг бичиж өгсөн. Сургууль, цэцэрлэгийн 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох сургалтыг 1 удаа зохион байгуулсан. Сургууль, цэцэрлэг бүр, гүйцэтгэлийн үр дүнд суурилсан байгууллагын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Энэ хичээлийн жилд 12 дугаар ангийг 1620 хүүхэд төгсөх нь улсын хэмжээнд хамгийн олон төгсөгч байгаа ба хэл бичгийн шалгалтад 721 сурагч орж, 309 хүүхэд тэнцэж, 42%-ийн гүйцэтгэлийн хувьтай гарсанд дүгнэлт хийж, цаашид эрчимтэй ажиллах талаар сургуулиудад үүрэг даалгавар өгч ажилласан. БШУГ-аас анги дэвших шалгалтын сэдвийн блюпринт, улсын шалгалтын сэдвийг боловсруулан, шалгалтын хуваарь, зөвлөмжийн хамт</p>	
--	--	--	--	--	--	--

						сургуулиудад хүргүүлэн, нэгтгэлийг авч, дүн шинжилгээ хийж эхэлсэн. Хүрсэн түвшин: 5	
3.1.7	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын дэргэд өөрийн санхүүжилтээр цэцэрлэг, салбар бүлэг, зуны цэцэрлэг байгуулах санал, санаачилгыг дэмжиж ажиллана	Улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	Тоо	4	Эхний хагас жилд: 3 Жилийн эцэст: 6	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 22 дугаар тогтоолоор Өлгий сумын ЕБ-ын 11 дүгээр сургууль, 227 дугаар тогтоолоор Толбо сумын 150 хүүхдийн 2-р цэцэрлэг, 229 дүгээр тогтоолоор Алтай сумын 100 хүүхдийн 2-р цэцэрлэг, 231 дүгээр тогтоолоор Ногооннуур сумын 100 хүүхдийн 3-р цэцэрлэг, 236 дугаар тогтоолоор Өлгий сумын 100 хүүхдийн 32 дугаар цэцэрлэг, 225 дугаар тогтоолоор 26 дугаар цэцэрлэг, 226 дугаар тогтоолоор 27 дугаар цэцэрлэг тус тус шинээр байгуулагдаж, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, холбогдох материалуудыг бүрдүүлж, сургалт эхлэх бэлтгэл ажлаа хангаж байна. Орон нутгийн төсвөөс Өлгий сумын 10, 11, 23, 24, 32 дугаар цэцэрлэгүүд болон 18, 19 дүгээр цэцэрлэгүүдийн салбар бүлгийн түрээсийн байрны төлбөр болох	100%

						394.0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Хүрсэн түвшин: 7 Хавсралт: 1 файл	
3.1.8	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн өөрийн удирдлагын байгууллага, хүүхэд бүрийн хөгжил, хамтын оролцоог дэмжсэн клуб, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжих, энэ чиглэлээр суралцагч, багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна	Орон нутгийн төсөв	Сурагчдын өөрийн удирдлагын байгууллагын тоо	116	Эхний хагас жилд: 96 Жилийн эцэст: 130	Аймгийн хэмжээнд ЕБС-иудад 5-8 төрлийн урлагийн болон спортын секц, дугуйланд 6105 хүүхэд хамрагдаж байна. Багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дуу хөгжим, биеийн тамир, дүрслэх урлаг, дизайн технологийн 112 багшид сургалт зохион байгуулсан. Хөгжмийн зохиолч С.Хурметийн хүүхдэд зориулсан уран бүтээлийг олон нийтэд сурталчлах, ерөнхий боловсролын сургуулиудын дуу хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж, хөгжмийн багш нарын найрал дуутай ажиллах арга барилыг сайжруулан ур чадварыг дээшлүүлэх, хүүхэд багачуудад хамтран дуулах чадварыг эзэмшүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх зорилгоор хүүхдийн найрал дууны дугуйлан, наадам зохион байгуулсан. Найрал дууны наадамд аймгийн төвийн 10 сургуулиас 600 гаруй	100%

						сурагч оролцсон болно. Сургууль бүр жилийн эцэст секц, дугуйлангийн тайлан тоглолтыг олон нийтэд тавьсан болно. Хүрсэн түвшин: 96 Хавсралт: 10 файл	
3.1.9	Хичээлээс гадуурх сургалтын ажлыг дэмжих, хүүхдийн оролцоо, хэрэгцээнд суурилсан секц, дугуйлангийн нэр төрлийг нэмэгдүүлнэ	Орон нутгийн төсөв	Хамрагдалтын хувь	72%	Эхний хагас жилд: 60% Жилийн эцэст: 74%	Хичээлээс гадуурх сургалт, секц, дугуйланг спортын холбоо, сургалтын төвүүдтэй хамтран зохион байгуулж, секц, дугуйлангийн нэр төрлийг нэмэгдүүлж байна. Сургууль бүр хүүхдийн оролцоо, хэрэгцээнд суурилсан 5-8 секц, дугуйланг тогтмол хичээлүүлж байгаа ба үүний үр дүн хөлбөмбөгийн 16, 14 насны хүүхдүүд Говь-Алтай аймагт болсон бүсийн тэмцээнд аварга болж, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож байна. Жүдо, чөлөөт бөхийн тамирчид улсын аварга шалгаруулах тэмцээнд алт, мөнгө, хүрэл медаль хүртэж, амжилттай оролцсон. Хүрсэн түвшин: 70% Хавсралт: 2 файл	100%

3.1.10	Ахлах ангийн 10-11 дүгээр ангийн цахим сургуульд сонгон судлах хичээлээ судалж буй суралцагчдын ирц, хамрагдалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ	0	Бүртгэгдсэн сурагчдыг 100 хувь хамруулах	100%	Эхний хагас жилд: 0 Жилийн эцэст: 100%	2023-2024 оны хичээлийн жилд ахлах ангийн 10-11 дүгээр ангийн цахим сургуульд сонгон судлах хичээлээр 10 дугаар ангид 22 сургууль сонгож 1562 сурагчдын 1066 буюу ирц 69,6 хувьтай, 11 дүгээр ангид 22 сургууль сонгож 1499 сурагчдаас 1020 буюу ирц 68,1 хувьтай тус тус хамрагдсан байна. Хүрсэн түвшин: Ахлах ангийн 10-11 дүгээр ангийн цахим сургуульд сонгон судлах хичээлийн хамрагдалт өмнөх оныхоос 46%-тай нэмэгдсэн	100%
3.1.11	ЕБС-ийн 8-12 дугаар ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох замаар тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцахад чиглүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ	0	Арга хэмжээний тоо	3	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 3	Аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр 1-6-р сард хийх ажлын төлөвлөгөө гаргаж, 2024 оны 1, 2-р сард Өлгий сумын ерөнхий боловсролын 1, 2, 3 дугаар сургуулийн 8, 9-р ангийн давхардсан тоогоор 400 сурагчид мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт хийсэн. Эрэлттэй мэргэжлээр их, дээд сургуульд элсэн суралцахад анги удирдсан багш нар чиглүүлэн ажиллаж байна. 12 дугаар	100%

						<p>анги төгсөж буй сурагчдад мэргэжлийн сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус үйлдвэр, үйлчилгээний газруудтай хамтран мэргэжлийн онцлог, үйл ажиллагаатай танилцах ажлыг зохион явуулсан.</p> <p>Хүрсэн түвшин: 1</p> <p>Хавсралт: 2 файл</p>	
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
4.1.	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлнэ	Улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	Хөрөнгө оруулалтын тоо, хэмжээ	Их засвар хийгдсэн цэцэрлэг-9, сургууль-16, дотуур байр-7, ариун цэврийн байгууламж-29	Ашиглалтад орсон сургууль-6, дотуур байр-2, ЕБС-ийн спорт заал-4, цэцэрлэг-7. Их засвар хийгдсэн цэцэрлэг-11, сургууль-17, дотуур байр-6, Сургуулийн өргөтгөл-1. Ариун цэврийн байгууламж-...	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилтын хүрээнд нийт 6 арга хэмжээ төлөвлөгдснөөс 83.3%-тай байна. 4.1.1 дэх арга хэмжээний биелэлт 50%-тай гарсан нь нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих төслийн IV ээлжид бүрэн хамрагдах судалгаа, тооцооллыг үнэн зөв, бодитой гаргаж, БЕГ-т тухайн үед хүргүүлсэн боловч ажил нь эхлээгүй, мөн зарим сургуулийн ариун цэврийн байгууламжийн зургийн өөрчлөлттэй холбоотой	83.3%

						болно.	
4.1.1	Төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих төслийн III, IV ээлжид бүрэн хамрагдах судалгаа, тооцооллыг үнэн зөв, бодитой гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах	Улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	Ашиглалтад орсон барилга байгууламжийн тоо	29	Эхний хагас жилд: 18 Жилийн эцэст: 31	Нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих төслийн IV ээлжид бүрэн хамрагдах судалгаа, тооцооллыг үнэн зөв, бодитой гаргаж, БЕГ-т тухайн үед хүргүүлсэн боловч ажил нь эхлээгүй. 1. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих төслийн I дүгээр ээлжийн ажил 2024 оны 5-р сарын 15-ны өдөр эхэлсэн. Гүйцэтгэгч "Мурап" ХХК нь Алтай, Алтанцөгц, Баяннуур, Дэлүүн, Улаанхус сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ажлыг гүйцэтгэж байна. Алтай, Алтанцөгц, Баяннуур сумын ажил 100% дууссан, улсын комисс ажилласан. Дэлүүн, Улаанхус сумын ажлын гүйцэтгэл-95%-тай. 2. Төслийн III дугаар ээлжийн ажил 2024 оны 05-р сарын 25-ны өдөр эхэлсэн байна. Гүйцэтгэгч "Тунгалаг буянт дуут" ХХК-ны гүйцэтгэж байгаа III дугаар ээлжийн 1-р багцын Өлгий сумын ЕБ-ын 1-р сургуулийн	50%

					<p>ажил-100%, ЕБ-ын 2-р сургуулийн ажил-90%, ЕБ-ын 5-р сургуулийн ажил 6-р сарын 15-ны өдрөөс эхэлнэ, ЕБ-ын 9 дүгээр сургуулийн ажил-100%, ЕБ-ын 6-р сургуулийн дотуур байрны ажил-100%, Цагааннуур тосгоны ЕБ-ын сургуулийн дотуур байрны ажил-90%-тай байна. 2-р багцын Баяннуур сумын Цагаан арал багийн ЕБ-ын сургуулийн ажил-90%, Цэнгэл сумын Засагт нуур багийн ЕБ-ын сургууль, Сагсай сумын Даян багийн ЕБ-ын сургууль нь зургийн өөрчлөлттэй холбоотой ажил эхлээгүй байна. 3. Төслийн III дугаар ээлжийн Булган сумын Ёлт багийн сургууль, Толбо сумын 3 ажил 2024 оны 03-р сарын 10-ны өдөр эхэлж, ажил бүрэн дууссан, улсын комисс ажиллах шатандаа байна. Алтай сумын Улаанхад бага сургуулийн дотуур байрны ажлын гүйцэтгэл-60%-тай. Гүйцэтгэгч "Пламбинг дэболопмент" ХХК нь Толбо сумын ЕБС, дотуур байр, цэцэрлэг, Булган сумын Ёлт багийн сургууль, Алтай сумын Улаанхад бага сургуулийн дотуур байрны ажлыг</p>	
--	--	--	--	--	--	--

						гүйцэтгэж байна. Хүрсэн түвшин: 7 Хавсралт: 1 файл	
4.1.2	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварыг хариуцаж, нөхөн хангалтын тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, засварт шаардлагатай санхүүжилтийг тухайн жилийн орон нутгийн төсөвт баталж, хуваарилан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Улсын болон орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	100%	Эхний хагас жилд: 40% Жилийн эцэст: 100%	1. Ерөнхий боловсролын 14 сургууль, 6 дотуур байр, 9 сургуулийн өмнөх боловсролын байгууллагын нийт 29 барилга байгууламжид нийт 1,233.7 сая төгрөгийн засвар хийгдэхээр 2024 оны төсөвт тусгагдаж, эрх шилжсэн. Нийт 29 арга хэмжээний 20 ажилд тендер зарлагдаж, ажлын явц 20-70%-ийн гүйцэтгэлтэй байна. Үлдсэн 9 ажилд тендер зарлагдсан, ажил нь эхлээгүй. 2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/181 дүгээр тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд олгох тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын санхүүжилтийн хуваарилалт батлах тухай” тушаалаар төрийн 52 цэцэрлэгт 140.5 сая төгрөг, 39 ерөнхий боловсролын сургуульд 1221.7 сая төгрөгийн төсөв хуваарилагдаж, худалдан	100%

						авалт хийгдэж байна. Хүрсэн түвшин: 70% Хавсралт: 1 файл	
4.1.3	Орон нутаг, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй боловсролын салбарын эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хуулиар баталсан зориулалт, хүчин чадал, байршил болон эдийн засгийн ангиллын дагуу зохион байгуулах, хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, тайлагнах	Улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	Хөрөнгө оруулалтын тоо, хэмжээ	Ашиглалтад орсон сургууль-1, дотуур байр-1, цэцэрлэг-5. Их засвар хийгдсэн цэцэрлэг-9, сургууль-16, дотуур байр-7.	Эхний хагас жилд: Ашиглалтад орсон сургууль-1, дотуур байр-1, ЕБС-ийн спорт заал-2, цэцэрлэг-3. Их засвар хийгдсэн цэцэрлэг-2, сургууль-1, дотуур байр-1. Жилийн эцэст: Ашиглалтад орсон сургууль-5, дотуур байр-2, ЕБС-ийн спорт заал-4, цэцэрлэг-5. Их засвар хийгдсэн цэцэрлэг-9, сургууль-14, дотуур байр-6. Сургуулийн өргөтгөл-1.	Боловсрол, шинжлэх ухааны салбарт 2024 онд хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлын явцад аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас тогтмол хяналт тавьж ажиллаж, аймгийн БШУГ-аас хөрөнгө оруулалтын ажлын явцын мэдээллийг сар бүр Боловсролын ерөнхий газарт хүргүүлэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 100 ортой цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон /Өлгий сумын 26 дугаар цэцэрлэг/. 2024.04.02-нд комисс ажиллаж, 2024 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн ББКД-83-11/24 дугаартай комиссын дүгнэлтээр баталгаажсан. Бусад барилгын ажлын гүйцэтгэл 15-96%-тай байна. Хүрсэн түвшин: Ашиглалтад орсон сургууль-0, дотуур байр-0, ЕБС-ийн спорт заал-0, цэцэрлэг-1. Их засвар хийгдсэн цэцэрлэг-2, сургууль-1, дотуур байр-1.	70%

						Хавсралт: 1 файл	
4.1.4	Орон нутаг, Улсын төсвийн хөрөнгөөр аймгийн боловсролын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, тайлагнах	Нийт төсөв: 3,760.0 сая 1. Улсын төсөв- 1,750.0 сая 2. Орон нутгийн төсөв- 2,010.0 сая	Хөрөнгө оруулалтын тоо, хэмжээ	ЕБС-ийн хатуу, зөөлөн эдлэл-124.0 сая, цэцэрлэгийн хатуу, зөөлөн эдлэл-144.9 сая, тоног төхөөрөмж-250.0 сая.	Эхний хагас жилд: ЕБС-ийн хатуу эдлэл-500.0 сая, цэцэрлэгийн зөөлөн эдлэл-200.0 сая, тоног төхөөрөмж-750.0 сая, БШУГ-ын эд хогшил-10.0 сая Жилийн эцэст: ЕБС-ийн хатуу эдлэл-1,500.0 сая, цэцэрлэгийн зөөлөн эдлэл-500.0 сая, тоног төхөөрөмж-1,750.0 сая, БШУГ-ын эд хогшил-10.0 сая	1. Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдээс санал авч, нэгтгэн, улсын төсөв болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний саналыг боловсруулан нээлттэй тендер зарлуулахаар аймгийн Засаг даргад бичгээр хүргүүлж, 2024 оны 03-р сарын 01-нд аймгийн Орон нутгийн өмчийн газраас https://www.tender.gov.mn цахим сайтад тавьж, нээлттэй тендер шалгаруулалт зарлагдсан. Тендер авсан компаниуд хөрөнгийн 80%-ийг нийлүүлсэн байна. 1.1 Улсын төсөв 1.0 тэрбум /ЕБС, цэцэрлэгүүдийн тоног төхөөрөмж, цэцэрлэгийн гадна талбайн тоглоом чийрэгжүүлэлт тоног төхөөрөмж, гал тогооны тоног төхөөрөмж/ 1.2. Улсын төсөв 0.75 сая төгрөг /Баяннуур, Сагсай, Дэлүүн сумын ЕБС, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, цэцэрлэгийн гадна талбайн тоглоом чийрэгжүүлэлт тоног	100%

						<p>төхөөрөмж, сурагчийн ширээ, сандал, зөөлөн эдлэл/ 2. Орон нутгийн төсвөөс хэрэгжүүлэх 2.0 тэрбум төгрөг /ЕБС, цэцэрлэгийн хатуу, зөөлөн эдлэл/-ийн төсөл, арга хэмжээний нээлттэй тендер шалгаруулалтыг 2024 оны 04-р сард зохион байгуулсан. Тендер нээгдэж, тендер авсан компаниуд хөрөнгийг нийлүүлэх шатандаа байна</p> <p>Хүрсэн түвшин: ЕБС-ийн хатуу эдлэл-0, цэцэрлэгийн зөөлөн эдлэл-0, тоног төхөөрөмж-1,168.5 сая, БШУГ-ын эд хогшил-10.0 сая</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
4.1.5	Шинээр баригдах шаардлагатай сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгын судалгааг гаргаж, зураг төсвийг хийлгэх	Улсын болон орон нутгийн төсөв	Хөрөнгө оруулалтын тоо, хэмжээ	0	Эхний хагас жилд: 0 Жилийн эцэст: 5	Монгол Улсын Сангийн сайд болон аймгийн Засаг даргаас ирсэн албан бичгийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд зайлшгүй шинээр барих шаардлагатай барилгын саналыг зураг төсөв, магадлалын дүгнэлтийн хамт ирүүлэх талаар аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэгүүдэд албан бичиг хүргүүлж, саналаа авсан. Саналаа	100%

						<p>нэгтгэж, аймгийн Засаг даргын 2024 оны 1-01/25 тоот албан бичгээр БШУ-ны сайдад хүргүүлсэн. /Өлгий сумын 4, 10, 11, 23 дугаар цэцэрлэгийн барилгыг шинээр барих, ЕБ-ын 11-р сургуулийн 150 хүүхдийн дотуур байрны барилгыг шинээр барих/ Хүрсэн түвшин: 0 Хавсралт: 1 файл</p>	
4.1.6	<p>Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэдээлэл, холбооны дэд бүтэц, сүлжээний төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, сайжруулах</p>	<p>Улсын болон орон нутгийн төсөв</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	70%	<p>Эхний хагас жилд: 70% Жилийн эцэст: 75%</p>	<p>Ерөнхий боловсролын сургууль бүрийг дотоод сүлжээ, интернэт орчноор бүрэн хангах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 2.2.6-д заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээс ерөнхий гэрээ байгуулсан Мэдээлэл, холбоо, сүлжээний газраас аймгийн бүх 39 сургуулийн 47 дотуур байр, 60 хичээлийн байрт нийт 888 утасгүй холболтын төхөөрөмж, 303 PoE Switch тавьж, 1,641.6 сая төгрөгөөр гэрээ хийж 24 сарын лизингтэй үйлчилгээг авсан</p>	100%

						Хүрсэн түвшин: 100% Хавсралт: 1 файл	
4.2.	Боловсролын салбартай холбоотой гарсан аливаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд хангуулна	0	Арга хэмжээний тоо	1	3	Боловсролын салбартай холбоотой гарсан аливаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд хангуулах зорилтын хүрээнд 5 арга хэмжээ төлөвлөгдөж, биелэлт 100%-тай байна.	100%
4.2.1	Сургалтын байгууллагуудын байр ашиглалт, харуул хамгаалалт, хоол үйлдвэрлэл, ариутгал цэвэрлэгээний болон орон нутгаас хариуцах бусад үйлчилгээг стандартад нийцүүлэн, тасралтгүй, тогтвортой хангана	0	Хэрэгжилтийн хувь	50%	Эхний хагас жилд: 40% Жилийн эцэст: 60%	Орон нутгийн төсвөөс Өлгий сумын 10, 11, 23, 24, 32 дугаар цэцэрлэгүүд болон 18, 19 дүгээр цэцэрлэгийн салбар бүлгийн түрээсийн төлбөрт нийт 394.0 сая төгрөгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 20 дугаар чуулганаар шийдвэрлэсэн. Хүрсэн түвшин: 100%	100%
4.2.2	Хөндлөнгийн болон дотоод аудитаас гарсан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангуулж ажиллана	0	Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт хангагдсан хувь	100%	Эхний хагас жилд: 75% Жилийн эцэст: 100%	1. Боловсролын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт бус шалгалтаар 2, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 2 төлөвлөгөөт шалгалтаар 5, нийт 96 заалттай хугацаат албан шаардлагыг 9 сургалтын байгууллагад хүргүүлсэн. 2 албан шаардагын хугацаа нь болж, зөрчлийг арилгуулсан ба 7 албан	100%

					<p>шаардлагын хугацаа нь болоогүй байна. 2. Аймгийн Төрийн аудитаас 2024 оны хагас жилийн байдлаар сургууль, цэцэрлэгүүдэд нийтдээ 37.3 сая төгрөгийн 14 ш төлбөрийн акт, 1321.6 сая төгрөгийн 22 ш албан шаардлага, 1921.4 сая төгрөгийн 97 ш зөвлөмж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцсон. Хууль тогтоомжтой холбоотой 2.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1424.5 сая төгрөгийн 4 албан шаардлага 1502.3 сая төгрөгийн 15 ш зөвлөмж 1 албан тушаалтанд хариуцлага тооцсон байна. 3. Аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн байдлаар 15 цэцэрлэг, 10 ерөнхий боловсролын сургуулийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт, аудит хийж, 4 цэцэрлэгт 2849.9 мянган төгрөгийн акт, 1 сургуульд 284.0 мянган төгрөгийн акт буюу бүгд 3133.9 мянган төгрөгийн акт тогтоосноос 433.1 мянган төгрөгийн актын төлбөр барагдсан, үлдсэн төлбөрийг</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>барагдуулах хугацаа нь болоогүй. Мөн 9 цэцэрлэг, 1 сургуульд нийт 77957.6 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, 2 цэцэрлэгээс албан шаардлагын биелэлт ирүүлсэн байна.</p> <p>Хүрсэн түвшин: 75%</p> <p>Хавсралт: 1 файл</p>	
4.2.3	<p>Ерөнхий боловсрол, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагын хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, тогтмол зардлын өр үүсгэхгүй байх, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний зардлыг хуваарилан хэрэгжүүлэх;</p>	0	Өр үүсгэхгүй байх	0	<p>Эхний хагас жилд: 0</p> <p>Жилийн эцэст: 0</p>	<p>Тус аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 39 сургууль, 51 цэцэрлэгийн тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 2024 онд 8,922.3 сая төгрөг хуваарилсан. Сургууль, цэцэрлэгийн тогтмол зардлын дутуу төлөвлөгдсөн 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 20 дугаар чуулганаар шийдвэрлүүлсэн.</p> <p>Хүрсэн түвшин: 0</p>	100%
4.2.4	<p>Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж, холбогдох хууль, дүрэм, журамд заасан хугацаанд тайлагнана</p>	0	<p>Мэдээлэлд хяналт хийж, цаг хугацаанд нь үнэн зөв мэдээлсэн байна.</p>	<p>СӨББ-ын 26, ЕБС-ийн 100, МСҮТ-ийн 10 төрлийн маягт Насан туршийн боловсролын төв 12 төрлийн маягт</p>	<p>Эхний хагас жилд: : СӨББ-ын 6, ЕБС-ийн 27, МСҮТ-ийн 10</p> <p>Жилийн эцэст: СӨББ-ын 26, ЕБС-ийн 100,</p>	<p>2023.11.27-ны өдрийн 2024.01.28-ны өдөр хүртэл 44 ерөнхий боловсролын сургууль, 1 насан туршийн боловсролын төвөөс сургалтын орчны тайланг 8 төрлийн маягтаар, 2023.11.01-2024.01.02-ны</p>	100%

					МСҮТ-ийн 10, Насан туршийн боловсролын төв 12 төрлийн маягт	өдөр хүртэл сурах бичиг, сурдаггүй хүүхдийн тайлан 9 төрлийн маягтаар, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тайланг 5 төрлийн маягтаар, 2024.02.19-ний өдрөөс 2024.03.18-ны өдөр хүртэл нийт хөрөнгө, төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланг 44 ерөнхий боловсролын сургууль, 1 насан туршийн боловсролын төв болон 57 хүүхдийн цэцэрлэгээс 6 төрлийн маягтаар, 2024.05.15-ны өдрөөс 2024.06.14-ний өдөр хүртэл хүүхдийн хамгаалал, оролцооны тайланг 6 төрлийн маягтаар авч, хяналт хийж цаг хугацаанд нь үнэн зөв мэдээлсэн болно. Хүрсэн түвшин: СӨББ-ын 6, ЕБС-ийн 34, НТБТ-ийн 14 Хавсралт: 4 файл	
4.2.5	Төсөв, санхүүгийн зарцуулалт, гүйцэтгэлийг Шилэн дансны хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлж, дотоод аудитын болон хяналтын тогтолцоог тогтмол ажиллуулна	0	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна	100%	Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100%	Сар бүрийн 03-ны өдөр дотор байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг байгууллагын даргаар баталгаажуулж, БШУЯамд хүргүүлж байна. Шилэн дансны мэдээллийг хууль тогтоомжийн дагуу	100%

						хугацаанд нь ил тод мэдээлж байна. Хүрсэн түвшин: 100%	
--	--	--	--	--	--	--	--

Үнэлсэн:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг)

.....
(огноо)

Тайлагнасан:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг)

.....
(огноо)